

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2003 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч
Ч.Ганбат

Дээд шүүхийн эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй **2003 он** шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах **багц хууль шинээр** батлагдсаныг хэрэгжүүлж ажилласан анхны жил, Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “ Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны Нэгдсэн зөвлөгөөн “-өөр “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, цаашдын зорилт”-ын асуудлыг хэлэлцэж хамтын шийдвэр гарган хуулийн байгууллагууд нэгэн Стратеги зорилтын дор ажилласан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн 10 жилийн ойг тэмдэглэсэн жил байлаа.

2003 он Монголын нийт шүүх, шүүгчид, шүүхийн байгууллагын ажилтнуудад ажлын ахиц дэвшил, дутагдал, бэрхшээлийн аль аль нь хосолсон жил байлаа.

2003 онд манай ихэнх шүүгч, ажилтнууд албан үүргээ зохих ёсоор амжилттай биелүүлж байгааг Төр засгаас өндрөөр үнэлж Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлигаар** Улсын Дээд шүүхийн шүүгч О.Зандраа, Ховд аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Тайванхүү, Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга Н.Дагва, Хөвсгөл аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга Ө.Ичинхорлоо, Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч Л.Сарангэрэл, тус шүүхийн шүүгч Ц.Түмэндэлгэр нарын **6** хүнийг “ **Алтан гадас**” одонгоор;

Улсын Дээд шүүхийн Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Г.Буяннэмэх, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Ерөнхий нягтлан бодогч А.Баасанжав, Төв аймгийн шүүхийн шүүгч Н.Түвшинжаргал, Архангай аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга Ч.Ууж, Нийслэлийн шүүхийн төрөлжсөн архивын эрхлэгч Д.Доржханд, Улсын Дээд шүүхийн сантехникийн слесарь Б.Ширэндэв нарын **6** хүнийг “**Хөдөлмөрийн хүндэт медаль**”-иар шагнасан билээ.

Түүнчлэн **Шүүхийн Ерөнхий зөвлөлийн тогтоолоор** Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч С.Батдэлгэр, Говь-Алтай аймгийн шүүхийн Тамгын хэлтсийн дарга Ж.Ганболд, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн ажлын албаны ахлах мэргэжилтэн А.Отгонцэцэг, Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгч С.Өнөр, ХБНГУ-ын Нюренберг хот дахь муж улсын Дээд шүүхийн шүүгч Ё. Кают, “Шүүх эрх мэдлийн шинэтгэл”-ийн хөтөлбөрийн захирал Хайке Грамскоу, тус төслийн мэргэжилтэн Чарлиз Феррел, Монгол Улсын гавъяат хуульч, доктор, Улсын Дээд шүүхийн дарга асан Б.Чимид, Улсын Дээд шүүхийн дарга асан, доктор Л.Ренчин, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга асан Г.Даштүдэв, тус зөвлөлийн гишүүн асан Н.Чадраабал нарын **11** хүнийг “**Шүүхийн тэргүүний ажилтан**” цол тэмдгээр;

Ерөнхий шүүгчийн захирамжаар Баянхонгор аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч асан, ахмад хуульч Л.Цэдэндамба, Улсын Их хурлын гишүүн Д.Дэмбэрэлцэрэн, Монгол Улсын гавъяат хуульч Ж.Авхиа нарын **3** хүнийг Улсын Дээд шүүхийн “**Хүндэт тэмдэг**”-ээр;

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын захирамжаар Улсын Дээд шүүхийн шүүгч М.Дамирансүрэн, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч асан Д.Дэмбэрэлцэрэн, Үндсэн хуулийн Цэцийн гишүүн, Хууль зүйн үндэсний төвийн захирал, академич Ж.Амарсанаа, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дарга Ц.Шаравдорж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Н.Ганбаяр, Үндсэн хуулийн Цэцийн гишүүн Ч.Дашням, өмгөөлөгч Ж.Энхчулуун, Нийслэлийн засаг дарга М.Энхболд, Төв аймгийн засаг дарга М.Мэндбилэг нарын **53** хүн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “**Хүндэт тэмдэг**”-ээр шагнагджээ.

Үүний зэрэгцээ зөрчил, дутагдал цөөнгүй гарч **шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг удаа дараа ноцтой зөрчсөн** Завхан аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Ю.Ганбат, Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Т.Батсайхан, Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Г.Баянжаргал;

Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Д.Ганхуяг, Баянхонгор аймгийн шүүхийн шүүгч Я.Бадамсүрэн, Говь-Сүмбэр аймгийн шүүхийн шүүгч Д.Түдэв, Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Б.Болд;

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн заалт, шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Ч.Боролзой;

Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн шийтгэх тогтоол нь хүчин төгөлдөр болсон Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Б.Сарантуяа, Дорноговь аймгийн шүүхийн шүүгч Д.Улаан нарын 9 хүнийг Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлигаар** шүүгчийн албан тушаалаас **огцруулж**;

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд Аймгийн шүүхийн **Ерөнхий шүүгчийн** албан тушаалд **тэнцэхгүй** тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Баянхонгор аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Г.Дэлгэрбямбыг **Ерөнхий шүүгчийн** албан тушаалаас;

Ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй тухай Шүүхийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан тул Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч С.Мөнхбаяр, Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч С.Цэрмаа, Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгч В.Дэлгэрмөрөн, Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч Б.Намхайдорж, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч Л.Нинжбат, Б.Оюун, Л.Сарангуа нарын 8 хүнийг Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлигаар** шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас **чөлөөлж**;

Эрүүгийн **хариуцлагад татах зөвшөөрөл** олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч С.Амар, Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн Ерөнхий шүүгч Л.Эхлэлт, Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Ч.Элдэв-Очир нарын 3 шүүгчийн бүрэн эрхийг **түдгэлзүүлж** Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлиг** гарсан юм.

Ийнхүү өнгөрсөн жилтэй харьцуулахад **огцорсон** шүүгч 7-оор, “шүүгчээр ажиллах боломжгүй” гэсэн дүгнэлт гарч шүүгчийн албан тушаалаас **чөлөөлөгдсөн** шүүгч 5-аар, Эрүүгийн **хариуцлагад татах зөвшөөрөл** олгож, хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг нь **түдгэлзүүлсэн** шүүгч 2-оор тус тус нэмэгдсэн байна.

2003 онд нийт 16 хүн шүүгчийн албан тушаалд томилогдсоноос 6 нь дэвшин, 6 нь шинээр, Ерөнхий шүүгчээр 2 шүүгчийг улируулан, 2 шүүгч өөр шүүхэд шилжин тус тус томилогдсон бөгөөд 14 шүүгч шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний 8 нь өөрийн хүсэлтээр, 5 нь өөр ажил албан тушаалд шилжиж, 1 шүүгч өндөр насны тэтгэвэрт гарчээ.

Мөн 5 шүүгчийг ажлын шаардлагаар нэг шүүхээс нөгөөд **сэлгүүлэн** ажиллуулахаар Монгол Улсын **Ерөнхийлөгчийн зарлиг** гарсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “**Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагын удирдах ажилтны Нэгдсэн зөвлөгөөн**”-ийг энэ оны 3 сарын 3-нд зохион байгуулж, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Ч.Ганбат “Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, цаашдын зорилтын тухай” үндсэн илтгэлийг тавьж хэлэлцүүлээ.

Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран зохион байгуулагдсан тус Нэгдсэн зөвлөгөөнд Ерөнхийлөгч Н.Багабандиас өгсөн үүрэг даалгавар, Зөвлөгөөнөөс гаргасан **зөвлөмж**, зөвлөгөөнд тавьсан **илтгэл**, хэлсэн **үгүүдэд дэвшүүлсэн** зорилтыг хэрэгжүүлэх, шинээр мөрдөгдөж байгаа багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судлан хууль, тогтоогчид өргөн мэдүүлэх, хуулийн албан ёсны тайлбар гаргах зэрэг ажлыг зохион байгуулах тухай хамтарсан тушаал, захирамж гарсан юм.

Түүнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран “Шүүхийн хуягийн ажиллах журам”, Улсын Ерөнхий Прокурорын газартай хамтран “Садан төрлийн холбоо тогтоох, нөхөх олговор авах тухай” нэхэмжлэл гаргах, түүнийг шүүх хүлээн авч шийдвэрлэж байгаа талаарх шүүхийн

практикийг нэгтгэн судалж, шаардлага хангаагүй нотлох баримтаар садан төрлийн харилцаа тогтоосон, нэг хэлмэгдэгчийн нөхөх олговрыг тухайн нэхэмжлэгчид эсхүл хоёр өөр нэхэмжлэгчид давхардуулан олгосон, нөхөх олговор авах эрхгүй этгээдэд олгосон, нотлох баримтын бүрдэл хангагдаагүй байхад олговрын асуудлыг шийдвэрлэсэн, нөхөх олговрыг олгосон тухай улсын хэмжээний Нэгдсэн бүртгэл, судалгаа гүйцэт хөтлөгдөөгүй байсан зэрэг зөрчлийг арилгах зорилгоор хамтарсан тушаал, захирамжууд гарган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Их хурал "Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай" болон "Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай" хууль, Захиргааны хэргийн шүүхэд ажиллах шүүгчийн орон тоо"-г баталсан тогтоол гаргасны дагуу Шүүхийн Ерөнхий зөвлөл Захиргааны хэргийн шүүхийг байгуулах **бэлтгэл ажлын графикийг** баталж, уг шүүхийн **захиргааны** болон **үйлчилгээний орон тоог** тогтоож, мөн шүүхийг байгуулах бэлтгэлийг хангаж байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөл "Шүүгчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах" журам, "Шүүгчийн албан хэрэг хөтлөлтөнд хэрэглэгдэх бүртгэлийн загвар", "Шүүгчийн сахилгын хэргийн үндсэн мэдээ", "Шүүгчийн мэргэшлийн хорооны дүрэмд өөрчлөлт оруулах тухай", "Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль" –ийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай зэрэг тогтоол гарган мөрдүүлэв.

Дээд шүүх 2003 оны ажлын төлөвлөгөөндөө **5** бүлэг **82** ажлыг төлөвлөснөөс **68** нь бүрэн биелэж, **8** ажил хойшлогдож, **6** ажил тасарсан байна. Тухайлбал:

Шүүгч М.Дамирансүрэнгийн боловсруулсан Эрүүгийн хуулийн 145, 146, 147, 148, 149, 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлын талаарх тайлбар;

Шүүгч А.Доржготовын боловсруулсан "Ашигт малтмалын тухай" "Банк,зээл,тооцоо"-ны талаарх хуулийн тайлбар;

Шүүгч Б.Доржготовын боловсруулсан "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59, 68 дугаар зүйлийн тайлбар" зэрэг нь төслөөр анхны хувилбар нь гарч Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж амжилгүй;

Танхимын тэргүүн Н.Төрбатын боловсруулах "Эрүүгийн хуулийн 74 дүгээр зүйлийн тайлбар", шүүгч М.Дамирансүрэнгийн боловсруулах "Эрүүгийн хуулийн 41, 43, 44 дүгээр зүйлд заасан ойлголтуудыг тайлбарлах", "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсгийн талаарх тайлбар", шүүгч Б.Доржготовын боловсруулах "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар бүлгийн талаарх тайлбар", "Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн талаарх тайлбар"-уудыг Эрүүгийн хэргийн танхим зөвлөгөөнөөрөө хэлэлцээд одоогоор тайлбарлах шаардлагагүй гэж үзэж ;

Шүүгч О.Зандраагийн "Компанийн тухай хуулийн зарим зүйл , заалтын талаарх тайлбар" уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болсонтой холбогдон;

Дээд шүүхийн товч танилцуулга товхимол хэвлүүлэн гаргах ажил төслөөр хийгдсэн боловч ирэх оны 6 дугаар сард Захиргааны хэргийн танхим байгуулагдахтай холбогдон тус тус хойшлогдсон байна.

Харин танхимын тэргүүнүүд боловсруулах учиртай "Шүүгчдийн ажил, үүргийн хуваарь, мэргэшэх чиглэлийн журам", "Эрүү, иргэний шүүн таслах ажиллагааны чиглэлээр баримтлах Нэгдсэн бодлого", шүүгч Д.Батсайханы боловсруулах "Эрүүгийн хуулийн 215, 216 дугаар зүйлд заасан гэмт хэргийн талаарх тайлбар", "Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 37, 38 дугаар бүлгийн зарим зүйл, хэсгийн талаарх тайлбар"-ын төсөл боловсруулах ажил уг ажлыг хариуцсан шүүгчдээс шалтгаалан тасалджээ.

Ийнхүү төлөвлөсөн **8** ажил хойшлогдож, **6** ажил тасалдсанд шүүгч, ажилтнууд дүгнэлт хийж, шинэ оны эхний улиралд хийж гүйцэтгэх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

Ерөнхий шүүгч **16** удаа иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагын төлөөлөгч, нийт **72** хүнтэй биечлэн уулзаж санал хүсэлтийг нь сонсож, зохих хариуг өгсөн байна.

Шүүгчдийн зөвлөлийн хуралдааныг 2003 оны 03 дугаар сарын 7-ны өдөр хуралдуулж, Шүүгчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж, “**Шүүгчийн ёс зүйн дүрэм**”-ийг шинээр батлан гаргасан байна.

Шүүхийн Хэвлэл мэдээллийн алба шүүх, шүүгчийн ажиллагаатай холбоотой **103** нийтлэл гарсныг бүртгэн, Ерөнхий шүүгчид тухай бүр нь танилцуулж, мөрөөр нь холбогдох арга хэмжээг авахуулж, эдгээрээс үндэслэл муутай нийтлэлийг няцаах зорилгоор **42** хариу тайлбар, залруулгыг сонинд нийтэлжээ. Мөн телевизээр Улсын Дээд шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бодит байдлыг гуйвуулсан нэвтрүүлэг явуулсан тул “Өнөөдөр”, “Монголын мэдээ”, “Өдрийн сонин” зэрэг сонингоор дамжуулан хариу **мэдэгдэл** гаргажээ..

Улсын Дээд шүүхийн тайлбар, тогтоолыг нийтэд ил тод байлгах, танилцах боломжоор хангах зорилгоор “Мэдээллийн нэгдсэн сан”-д Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамж **14**, 2000-2003 онд хууль тайлбарласан тогтоол **28**, орон нутгийн шүүхийн ажлыг шалган тусалсан дүнгийн тухай тогтоол **12**, шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий эрүүгийн **69**, иргэний **65** тогтоол, Эрүү, Иргэний хэргийн танхимуудын гаргасан зөвлөмж **4**-ийг тус тус оруулсан байна.

Улсын Дээд шүүхээс эрхлэн гаргаж байгаад санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан хэвлэгдэхгүй байсан “**Монгол Улсын Дээд Шүүхийн Мэдээлэл**” сэтгүүлийг АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар эрхлэн гаргаж, бүх шатны шүүхийн шүүгчид болон бусад холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Түүнчлэн “**Улсын Дээд шүүхийн Вэф сайт**”-ын эхийг бэлтгэж, “**Улсын Дээд шүүхийн 2002 оны жилийн ажлын тайлан**”-г ном болгон хэвлүүлэв. Шүүхийн **2003 оны тайлан** ч ном болж хэвлэгдэн гарах болно.

“Ханнс–Зайделийн сан”-ийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар Аймаг, нийслэл, зарим сум дунд, дүүргийн шүүхийн **Ерөнхий шүүгчдийн Нэгдсэн зөвлөгөөн** семинарыг 2003 оны 3 дугаар сарын 4-6-ны хооронд Нийслэлд зохион байгуулав.

Засгийн газрын 1996 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-ын дагуу бүх шүүгчид, тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдаас “**Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг**”-ийг 2002 оны байдлаар гаргуулан авч, шүүгчдийн “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, ажилтнуудын “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референтэд өгч хадгалуулж байна.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”, “Шүүхийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль шинэчлэгдэн батлагдаж мөрдөгдсөнтэй холбогдуулан байгууллагын “**Хөдөлмөрийн дотоод журам**”-ыг дээрх хуулийн зүйл, заалтуудад нийцүүлэн шинэчлэн, Ерөнхий шүүгчийн 2003 оны 815 дугаар захирамжаар баталсан.

Дээд шүүхийн эрүү, иргэний хяналтын шатны шүүн таслах ажлын мэдээ гарч, Эрүү, Иргэний хэргийн танхим, Тамгын газар, Шүүхийн судалгааны төвийн тайлан тухайн нэгж, хамт олноороо нэгэнт хэлэлцэгдэж, Ерөнхий шүүгч түүнд биечлэн оролцсон тул Дээд шүүхийн 2003 оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулья.

Нэг. Шүүн таслах ажлын талаар

Дээд шүүхийн \Нийт шүүгчдийн\ хуралдааныг 8 удаа зарлан нийт 11 өдөр хуралдуулж, бүгд 36 асуудал хэлэлцэж, тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг 11, иргэний хэрэг 7, аймгийн шүүхийг иж бүрнээр шалган тусалсан дүнгийн тухай мэдээлэл 7, хуулийн тайлбар 9-г хэлэлцэж шийдвэр гаргав.

Өнгөрсөн жилтэй харьцуулахад Дээд шүүхийн \нийт шүүгчдийн\ хуралдаан хийсэн өдөр **31**-ээр, хэлэлцсэн асуудлын тоо **296**-аар, эрүүгийн хэрэг **46**-аар, иргэний хэрэг **183**-аар тус тус цөөрсөн мэт харагдаж байгаа боловч энэ нь “хяналтын шатны ачаалал багассан” гэсэн үг огт биш бөгөөд уг чиг үүргийг **5 шүүгч** бүхий хяналтын шатны эрүү, иргэний хуралдаан шийдвэрлэдэг

болсонтой холбоотой **тоон** өөрчлөлт гарсан нь энэ бөгөөд, харин аймаг, нийслэлийн шүүхийг шалгасан ажил **3**-аар, хуулийн тайлбар **2**-оор нэмэгджээ.

Эрүүгийн хэргийн танхим хяналтын журмаар эрүүгийн **775**, цагаатгалын **161**, нийт **936** хэрэг хүлээн авч, түүний **96** хувь буюу эрүүгийн **741**, цагаатгалын **158** хэргийг хянаж шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар шүүгч М.Дамирансүрэн **181**, С.Нямжав **174**, Б.Доржготов **172**, Д.Батсайхан **168**, Танхимын тэргүүн Н.Төрбат **82** эрүүгийн **хэрэг хүлээж авсан** ба одоо танхимын хэмжээнд **40 хэрэгт** ажиллагаа хийгдэж байна.

Хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд шүүгч Б.Доржготов **450**, Д.Батсайхан **440**, М.Дамирансүрэн **440**, С.Нямжав **425**, Танхимын тэргүүн Н.Төрбат **331** удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Н.Төрбат **284**, шүүгч М.Дамирансүрэн **54**, Б.Доржготов **45**, Д.Батсайхан **44**, С.Нямжав **41** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**,

Шүүгч М.Дамирансүрэн **135**, Б.Доржготов **125**, С.Нямжав **100**, Д.Батсайхан **78**, Танхимын тэргүүн Н.Төрбат **47** хэрэг тус тус **илтгэсэн** байна.

Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт **64** өдөр хуралдаж, **өдөрт 1-17** хэрэг хэлэлцэж, бүгд **486** хэрэг хянан шийдвэрлэсний **89,3** хувь буюу **434** нь эрүүгийн, **10,7** хувь буюу **52** нь цагаатгалын хэрэг байв.

Дээд шүүхийн **хяналтын шатны** шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **434** эрүүгийн хэргийн **52,3** хувь буюу **227** тогтоол, магадлалыг **хэвээр үлдээж**, **24,2** хувь буюу **105** нь **өөрчлөгдөж**, **23,5** хувь буюу **102** хэргийн тогтоолыг **хүчингүй** болжээ.

Өөрчлөгдсөн **105** хэргийн **3,8** хувь буюу **4** нь эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, **11,4** хувь буюу **12** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **24,7** хувь буюу **26** нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, **66,6** хувь буюу **70** хэрэгт бусад өөрчлөлт орсон.

Хүчингүй болсон **102** хэргээс **56** хэргийг прокурорт, **37** хэргийг **шүүхээр дахин хэлэлцүүлэхээр** буцааж, **8** хэргийг **хэрэгсэхгүй** болгосон байна.

Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн **52** цагаатгалын хэргээс **13,4** хувь буюу **7** нь овог, нэр өөрчлөх, **84,6** хувь буюу **44** нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах, **1,9** хувь буюу **1** хэргийн тогтоолыг хэвээр үлдээж, прокурорын дүгнэлтийг хэрэгсэхгүй болгожээ.

Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанаар хянагдсан эрүүгийн хэргээс Нийслэлийн **34**, Булган **7**, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Орхон, Хөвсгөл аймгийн тус бүр **5**, Баянхонгор, Говь-Алтай, Төв аймгийн тус бүр **4**, Архангай, Дорноговь, Өмнөговь, Ховд аймгийн тус бүр **3**, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс аймгийн тус бүр **2**, Дорнод, Дундговь аймгийн тус бүр **1** хэргийн тогтоол, магадлал хүчингүй болсон байхад Хэнтий аймгаас хүчингүй болсон тогтоол байхгүй байна.

Нийслэлийн **46**, Дорнод **7**, Говьсүмбэр, Увс аймгийн тус бүр **5**, Баян-Өлгий, Говь-Алтай, Орхон, Төв аймгийн тус бүр **4**, Булган, Говьсүмбэр, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймгийн тус бүр **3**, Баянхонгор, Хөвсгөл аймгийн тус бүр **2**, Дорноговь, Завхан, Хэнтий аймгийн тус бүр **1** хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оржээ.

Дээд шүүхийн **Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **11** хэрэг хэлцэгдсэний **3** нь Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр, **8** хэрэг нь цаазаар авах ялтай учир "Шүүхийн тухай" хуулийн дагуу хянагдсан байна.

Хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн **93,1** хувь буюу **404** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн гомдлоор, **18,9** хувь буюу **82** нь яллагчийн эсэргүүцлээр хэлэлцэгджээ.

Нийслэл болон дүүргийн шүүхүүдийн нийт **189** хэрэг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлцэгдсэнээс **109** хэргийн тогтоол, магадлал **хэвээр** батлагдаж, **46** нь **өөрчлөлт** орж, **17,9** хувь буюу **34** хэргийн тогтоол, магадлалыг **хүчингүй** болгосоны **18** хэргийг мөрдөн байцаалтанд, **11** хэргийг **шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт** буцааж, **5** тогтоол, магадлалыг **хүчингүй** болгож **хэргийг хэрэгсэхгүй** болгожээ.

Энэ онд шүүгч Д.Батсайхан **83**, С.Нямжав **77**, Б.Доржготов **62**, М.Дамирансүрэн **42**, танхимын тэргүүн Н.Төрбат **39** эрүүгийн хэргийг тус тус **уншиж хянаад буцаасан** байна.

Тус танхим 2003 онд нийт **276** өргөдөл, гомдол хүлээн авснаас шүүгч М.Дамирансүрэн **95**, тэргүүн Н.Төрбат **87**, Б.Доржготов **52**, С.Нямжав **40**, Д.Батсайхан **38**, өргөдлийг хянан шийдвэрлэж, одоо **10 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгчид хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанд нийт **335** удаа оролцсоноос Танхимын тэргүүн Н.Төрбат **15-г** даргалж, **29** хэрэг шийдвэрлэхэд оролцсон бөгөөд шүүгч Б.Доржготов **118**, С.Нямжав **63**, Д.Батсайхан **58**, М.Дамирансүрэн **52** удаа тус тус оролцжээ.

Иргэний хэргийн танхимын шүүгч нар иргэд, байгууллагаас нийт **243** өргөдөл, гомдол хүлээн авч, **228-ыг** нь буюу **93,8** хувийг шийдвэрлэжээ. Үүнд: шүүгч Ц.Амарсайхан **4**, А.Доржготов **29**, О.Зандраа **22**, Д.Тунгалаг **19**, Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **154** өргөдөл, гомдол шийдвэрлэж, одоо **15 өргөдлийн** үлдэгдэлтэй байна.

Энэ онд тус танхим **хяналтын журмаар** нийт **1090** хэрэг хүлээн авч, иргэний **802** хэргийг **5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй** хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, **343** хэргийг хяналтын шүүх хуралдаанд оруулах үндэслэлгүй учир буцаажээ. Одоо **36** хэргийн үлдэгдэлтэй байна.

Шүүгч Ц.Амарсайхан **272** хэрэг хүлээн авч, **261-г шийдвэрлэж**, үүнээс **191** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч О.Зандраа иргэний **262** хэрэг хүлээн авч, **258-г шийдвэрлэж**, үүнээс **194** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч А.Доржготов **250** хэрэг хүлээн авч, **243** хэргийг **шийдвэрлэж**, үүнээс **198** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Шүүгч Д.Тунгалаг **249** хэрэг хүлээн авч, **240-г шийдвэрлэж**, үүнээс **180** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн;

Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **148** хэрэг хүлээн авч, **143-г шийдвэрлэж**, үүнээс **29** хэргийг хуралдаанд **илтгэж** шийдвэрлүүлсэн байна.

2003 онд Дээд шүүхийн **Иргэний хэргийн хяналтын** шатны шүүх хуралдаан **76** өдөр хуралдаж, өдөрт дунджаар **11** хэрэг хэлэлцэн, нийт **794** хэрэг шийдвэрлэжээ.

Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **680** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос 625** хуралдааныг **даргалж**;

Шүүгч А.Доржготов **691** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос, 70** хуралдаан **даргалж**;

Шүүгч О.Зандраа **780** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос, 33** хуралдаан **даргалж**;

Шүүгч Ц.Амарсайхан **707** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос, 17** хуралдааныг **даргалж**;

Шүүгч Д.Тунгалаг **742** хэрэг шийдвэрлэхэд **оролцсоноос, 16** хуралдаан тус тус **даргалсан** байна.

Иргэний хэргийн танхимын шүүгчид хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдаанд нийт **308** удаа оролцсоноос Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил **15** хуралдааныг даргалж, **34** удаа, шүүгч

Б.Доржготов **46**, О.Зандраа **95**, Ц.Амарсайхан **56**, Д.Тунгалаг **76** хэрэг шийдвэрлэхэд тус тус оролцсон байна.

Тус танхим **36** хэргийн үлдэгдэлтэй ч хугацаа хэтэрсэн хэрэг байхгүй байна.

Иргэний хэргийн танхимаас 2003 онд шүүгчийн захирамж **190**-ыг гаргаснаас Танхимын тэргүүн Р.Жамъянчойжил Гомдлыг хэлэлцэхээс татгалзах тухай **53**, Гомдлыг гаргаагүйд тооцох тухай **1**, Улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай **5**, нийт **59**, бусад шүүгчид улсын тэмдэгтийн хураамж буцааж олгосон болон хэрэг хэлэлцэхээс татгалзсан **131** захирамж гаргажээ.

Улсын Дээд шүүхийн хуралдаанд хуулийн тайлбарын **4** төсөл хэлэлцүүлж батлуулжээ.

Улс төрийн намуудын тухай хуульд заасан бүрэн эрхийн дагуу “Иргэний зориг- Бүгд Найрамдах намын үйл ажиллагааг зогсоох, Монголын Бүгд Найрамдах намын үйл ажиллагааг сэргээн тогтоолгохыг хүссэн” хүсэлтийг Улсын дээд шүүхийн иргэний хэргийн танхимын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Хоёр. Шүүхийг мэргэжил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах арга зам нь хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг нэг мөр зөв ойлгон мөрдүүлэх талаар албан ёсны тайлбар гаргах, тэдний ажлыг шалган туслах, шүүгч, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулах, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс хамтын удирдлага, зохион байгуулалтын аливаа шийдвэр гаргахад нь Дээд шүүх, Ерөнхий шүүгч, Ерөнхий Зөвлөлийн гишүүн шүүгчдээс үзүүлэх нөлөөг эрс дээшлүүлэх явдал юм.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүхээс “Шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” / Ц.Амарсайхан, О.Зандраа /; “Прокурорын байгууллагын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” / Ц.Амарсайхан, О.Зандраа /; “Өмгөөллийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” / Ц.Амарсайхан, О.Зандраа /; “Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн Зэвсэгт хүчний бүтэц гэсэн ойлголтыг тайлбарлах тухай” / М.Дамирансүрэн /; “Эрүүгийн хуулийн 34, 35, 36, 37 дугаар зүйлийн заалтыг тайлбарлах тухай” /Б.Доржготов /; “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” / Д.Тунгалаг /; “Эрүүгийн хуулийн 91 дүгээр зүйлийг тайлбарлах тухай” / Н.Төрбат /; “Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийг тайлбарлах тухай” / Н.Төрбат /; “Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг тайлбарлах тухай” / М.Дамирансүрэн / зэрэг **хуулийн тайлбар 9**-г гаргасан нь эдгээр хуулийг нэг мөр зөв ойлгон хэрэглэх, шүүхийн практикийг нэгдмэл тогтооход ач холбогдлоо өгнө гэж үзэж байна.

Захиргааны хариуцлагын тухай, Патентын тухай, Ашигт малтмалын тухай хуулийн тайлбар төслийн хэмжээнд хийгдсэн ба шинээр батлагдсан багц хуулиудыг бүлэг тус бүрээр шүүгч нар хуваарилан авч тэдгээрийн зарим зүйл, заалтын талаар Дээд шүүхийн тайлбарыг боловсруулахаар ажиллаж байна.

Компанийн тухай хуулийн тайлбар нь уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаатай холбоотойгоор хойшлогдсон болно.

Дээд шүүхийн Нийт шүүгчдийн **хуралдаанаар Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Хөвсгөл, Сүхбаатар** аймгийн шүүх, тэдгээрийн харъяа сум дундын шүүхийн ажлыг иж бүрнээр нь шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэн **тогтоол 5, Дорноговь, Архангай, Баянхонгор, Говь-Сүмбэр, Завхан** аймгуудын шүүх, тэдгээрийн харъяа сум дундын шүүхийн ажлыг хэсэгчлэн шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэн тогтоол **2**, тэмдэглэл **3** тус тус гарган холбогдох шүүхүүдэд хүргүүлжээ.

Түүнчлэн “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хориход шүүгчээс анхаарах зарим асуудал”-ын талаар **зөвлөмж** гарган, уг асуудлаарх шүүгчийн захирамж, бүртгэлийн **загвар** гаргаж нийт шүүх, шүүгчдийн гарын авлага болгон хүргүүлжээ.

2003 онд Эрүү, Иргэн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн тухай зэрэг багц хуулиудыг хэрэглэх явцад тулгарч буй асуудлуудыг Аймаг, нийслэл,

сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчдийн зөвлөлгөөн семинарын үед сонсч, шаардлагатай гэж үзвэл хуулийн бусад байгууллагууд, Засгийн газар, УИХ-тай ярилцан хуульд өөрчлөлт оруулах, дээрх хуулийн зарим зүйл, заалтад Улсын Дээд шүүхээс хуулийн **тайлбар**, шаардлагатай **тойм, зөвлөмжийг** гаргах ажлыг үргэлжүүлэн гүйцэтгэх болно.

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах, шинэ 2004 онд шүүхийн байгууллагын шийдвэрлэх зорилтыг тодорхойлж, цаашид хийх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч нарын жил бүрийн **“Ээлжит цугларалт, семинар”**, **“Нэгдсэн зөвлөлгөөн”** ямагт чухал ач холбогдолтой байдаг. Үүнд одооноос сайтар бэлтгэж, Аймаг, нийслэлийн **22**, сум болон сум дунд, дүүргийн **38** шүүх, тэдгээрийн шүүгчдийн ажилд Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс тогтоосон ажлын үзүүлэлтээр үнэлэлт дүгнэлт өгч, байр эзлүүлэн урамшуулбал зохино.

Ялангуяа тодорхой хэрэг маргааныг хяналтын журмаар хэлэлцэж шийдвэрлэн, ажлын ачааллынхаа ихийг гайхаж суухад бус харин шинэ багц хуулиудын зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэхэд шаардлагатай албан ёсны тайлбарыг яаралтай батлан гаргаж, үүсч болох гомдол, маргааныг багасгахад голлон анхаарах нь зүйтэй юм.

Гурав. Тамгын газрын ажлын талаар

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс дотоод ажил, зохион байгуулалтын талаар өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоог бүрдүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангах, шүүхийн статистик мэдээг гаргах, шүүгчийг шаардлагатай хууль тогтоомж, холбогдох мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах, батлагдсан төсвийн хөрөнгийг зохих зардлаар нь үр ашигтай зарцуулж өр гаргахгүй ажиллах, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хэрэгжүүлэх талаар анхааран ажиллажээ.

Шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн дагуу Төрийн захиргааны албан хаагчидтай **“Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ”**-г байгуулж, үйлчилгээний албан хаагчидтай байгуулдаг **“Хөдөлмөрийн гэрээ”**-г энэ оноос эхлэн улиралаар байгуулж, түүнд тавигдсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллаж иржээ.

Тамгын газрын ажилтнуудыг **“Эрх зүйн мэдлэгийн сонжуур”**, **“Баримт бичиг боловсруулах чадвар”**, **“Хууль хэрэглэх ур чадвар”**, **“Компьютер дээр ажиллах чадвар”** гэсэн **дөрвөн** үзүүлэлтээр шалгаруулан ажилд авах болсон нь үр дүнтэй болов.

Тамгын газрын даргын зөвлөл 6 удаа хуралдаж, Улсын Дээд шүүхийн 2002 оны жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудад цалинтай болон цалингүй чөлөө олгох, цалинг нь урьдчилан олгох, эрүүл мэндийн болон амьдралын хүнд байдал, ар гэрт нь хөрөнгө мөнгөний гачигдал тохиолдсон ажилтнууд, ахмадын зөвлөлийн зарим гишүүдэд буцалтгүй тусламж олгох, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан, ажил тасалсан, ажлын байранд архидан согтуурсан зарим ажилтнуудад сахилгын шийтгэл ногдуулах зэрэг нийт **18 асуудлыг** хэлэлцэн, **Тамгын газрын даргын тушаалаар** шийдвэрлэжээ.

Тамгын газрын даргын 2002 оны 23 дугаар тушаалаар 40 нэрийн **10425336** төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж данснаас хасах, Төрийн өмчийн хорооны тогтоолын дагуу бусад байгууллагад шилжүүлэн өгөх, акталсан эд зүйлсийг худалдан борлуулах зэргээр шийдвэрлэжээ.

Санхүү, Эдийн засгийн сайдын 2003 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг явуулах ажлын удирдамж”-ийн дагуу Нийслэл болон орон нутгийн төрийн байгууллагуудад зохион байгуулагдсан **“Анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтлөлт”**-ийн **улсын үзлэгт хамрагдан хангалттай дүн** үзүүллээ. Одоо удахгүй болох **Аудитын шалгалтанд** мөн ийм дүн үзүүлэх нь чухал.

“Амьсгалын цочмог халтай хам шинж өвчин”-өөс сэргийлэх; “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх”; Ахмадын зөвлөлийн гишүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх; Клиникийн нэгдсэн 2 дугаар эмнэлэг болон Төрийн тусгай албан хаагчийн нэгдсэн эмнэлгээр шүүгч, ажилтнуудыг үйлчлүүлэх зэрэг асуудлыг тухай бүр нь зохион байгуулж байв.

Үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаа талаар **8** хүний ажлыг шалгаж, **заавар зөвлөгөө** өгчээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын санал болгосноор сум, сум дунд, дүүргийн шүүхээс садан төрлийн холбоо тогтоосон тухай **2100** гаруй иргэний хэргийг татан ирүүлж, шүүхийн практикийг нэгтгэн судалж, тэдгээр хэргүүдээс нөхөх олговор давхардуулан гаргуулсан **30**, хууль зөрчсөн **2** хэргийг дахин хянуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргаж, Улсын Ерөнхий прокурорын газарт шилжүүлэн, алдаа зөрчлийг арилгуулсны дээр шүүхийн практик судалсан асуудлаараа зөвлөмж, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын хамтарсан **”Журам тогтоож, хэрэгжүүлэх тухай”** захирамж, тушаал гаргуулан нийт шүүхүүдэд хүргүүлсэн байна.

Төрийн холбооны телефон утасны кабель ашиглан, тэдний зөвшөөрлийн дагуу “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслөөс өгсөн сервирын тусламжтайгаар өөрийн байгууллагын компьютерийн сүлжээг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын сүлжээнд холбуулснаар манай байгууллагын дотоод сүлжээний компьютерүүд **интернэтийн сүлжээнд** холбогдон ажиллаж байна.

Байгууллагын дэргэдэх **“Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс”**-ыг Ерөнхий шүүгчийн захирамжаар шинэчлэн батлуулж, архивт өгөөгүй байсан 2002 оны баримтыг хариуцсан ажилтнуудаас хүлээн аван бүртгэлд оруулж, архивын үйл ажиллагааг цэгцлэв.

Ханнс-Зайдалын сан, Азийн хөгжлийн сан, ОХУ-ын Буриад Улсын Дээд шүүхээс бэлэг болгосон **34** нэрийн **41** ном, **518,1** мянган төгрөгөөр худалдан авсан **33** нэрийн **70** ном, нийт **111** номыг номын сандаа шинээр бүртгэн, **5** төрлийн сонин, **2** төрлийн монгол, **2** төрлийн орос сэтгүүлийг ангилан дугаараар нь байрлуулж, шинээр номын санд бүртгэгдсэн ном, сэтгүүлийн тухай **“Мэдээлэл”**-ийг **6** удаа хийжээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудад **35** нэрийн **85** ширхэг номыг олгож, албан хэрэгцээнд ашиглуулсан байна.

Хуулийн төв байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон зохиогддог **“Шилжин явах цомын төлөө спортын тэмцээн”**-д манай баг тамирчид амжилттай оролцож, **“Боулинг”**, **“Сагсан бөмбөг”**-ийн тэмцээнүүдэд тэргүүлж **“Алтан медаль”**, **“Гар бөмбөг”**, **“Теннис”**-ний тэмцээнд **2, 3 дугаар** байр эзэлж, **“Мөнгө, Хүрэл медаль”** тус тус хүртэж, багуудын нийлбэр дүнгээр **2 дугаар** байр эзэллээ.

Улсын Дээд шүүхийн 2003 оны батлагдсан төсөв **167,7** сая төгрөг байснаас, **10,0** сая төгрөг нь цахилгааны их засварын зардалд, үлдэх **157,7** сая төгрөг нь **урсгал зардлын төсөв** байсан.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- **Бичиг хэрэг**, аж ахуйн зардалд **5.325,0** мянган төгрөг төлөвлөснөөс **6,092,3** мянган төгрөг зарцуулсан бөгөөд **767,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- **Гэрэл цахилгааны** зардалд **2,667,6** мянган төгрөг төлөвлөснөөс **2,808,0** мянган төгрөг зарцуулж, **140,7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Түлш, халаалтын зардалд **13,242,7** мянган төгрөг төлөвлөснөөс **12,373,1** мянган төгрөг зарцуулж, **869,6** мянган төгрөг хэмнэсэн;
- **Тээвэр, шатахууны** зардалд **5,754,3** мянган төгрөг төлөвлөснөөс **6,119,0** мянган төгрөг зарцуулж, **364,7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- **Шуудан, холбооны** зардалд **9,146,4** төгрөг төлөвлөснөөс **11,173,0** мянган төгрөг зарцуулж, **2,026,6** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Цэвэр, бохир усны зардалд **984,0** мянган төгрөг төлөвлөснөөс **316,4** мянган төгрөг зарцуулж, **667,6** мянган төгрөг хэмнэсэн;

- **Дотоод албан томилолтын** зардалд **1,200,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2,089,6** мянган төгрөг зарцуулж, **889,5** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гадаад албан томилолтын зардалд **5,320,0** мянган төгрөг төлөвлөснөөс **6,242,3** мянган төгрөг зарцуулж **922,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- **Ном, хэвлэл авах** зардалд **720,0** мянган төгрөг төлөвлөснөөс **1,065,9** мянган төгрөг зарцуулж, **345,9** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Нормын хувцас авах зардалд **127,5** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **113,6** мянган төгрөг зарцуулж, **13,9** мянган төгрөг хэмнэсэн;
- **Урсгал засварын** зардалд **500,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **2,030,3** мянган төгрөг зарцуулж, **1,530,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- **Гадаад зочны** зардалд **5,100,0** мянган төгрөг төлөвлөснөөс **5,972,2** мянган төгрөг зарцуулж, **872,2** мянган төгрөгөөр хэтэрсэн;
- Байрны түрээсийн зардалд **303,4** мянган төгрөг төлөвлөгдсөнийг бүгдийг зарцуулсан;
- **Буцалтгүй тусламж, тэтгэлэг урамшууллын** зардалд **6,361,2** мянган төгрөг төлөвлөснөөс **6,906,1** мянган төгрөг зарцуулж, **544,9** мянган төгрөгөөр **хэтэрсэн** ;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **1,173,0** мянган төгрөг төлөвлөгдснөөс **3,100,0** мянган төгрөг зарцуулж, **1,127,0** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- **Бараа үйлчилгээний** бусад зардалд **51,563,7** мянган төгрөг төлөвлөснөөс **59,799,3** мянган төгрөг зарцуулж, **8,235,6** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Нийгмийн даатгалын шимтгэлд **20,841,1** мянган төгрөг төлөвлөснөөс **19,442,1** мянган төгрөг зарцуулж, **1,399,0** мянган төгрөг хэмнэсэн;
- Цалин хөлс , нэмэгдлийн зардалд **78,943,0** мянган төгрөг төлөвлөгдснөөс **63,017,7** мянган төгрөг зарцуулж, **15,925,3** мянган төгрөг хэмнэгдсэн байдалтай байна.

Зарим зардал “хэмнэгдсэн” мэтээр харагдаж байгаа нь “төсөв хангалттай бөгөөд зарцуулах зүйл олдоогүй”-гээс бус, харин төлөвлөгдсөн төсөв нь хүрэхгүй, хэтэрэхэд хүрсэн нь бусад зардлаас нөхөн санхүүжүүлж, “урд хормойгоороо хойд хормойгоо нөхөхөд” хүрч байсныг энд зориуд тэмдэглэж байна. Тэгэхээр шүүгч, ажилтнууд бид байгууллагын төсвийн аль нэг зардлыг хэтрүүлэх нь өөр нэг зардлыг зориулалтаар нь хэрэглэж чадахгүйд хүрэх муу үр дагавартайг цаашид анхаарвал зохино.

2003 онд шүүгч, ажилтнуудынхаа ая тухтай ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний **нийгмийн асуудлыг** шийдвэрлэх, зарим хүмүүсийг **шагнаж урамшуулах**, байгууллагын **тохижилт, засвар, үйлчилгээ**, бичиг **хэргийн зардал** болон бусад зардалд нийт **23,4** сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ тухай мэдээлэл Тамгын газрын тайланд маш тодорхой байгаа болно.

Түүнчлэн энэ онд нийт **түрээсийн орлого** болох **8,561,8** мянган төгрөгнөөс төсвийн зардал мөнгө хүрэлцдэггүй бусад арга хэмжээнүүдэд зарцуулж, одоо **1,0** сая төгрөг үлдсэнийг байгууллагын **Шинэ жилийн арга хэмжээнд** зарцуулна.

Түрээсийн орлогыг хэрхэн зарцуулсан талаархи мэдээллийг Тамгын газрын тайлангаас тодорхой үзээрэй.

Шинэчлэгдэн батлагдсан “**Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам**”-д заасны дагуу 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс ажилтнуудад **хоолны зардлыг ажлын өдөр** тутамд **1000** төгрөгөөр тооцон олгохоор шийдвэрлэсэн нь нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болно гэж үзэж байна.

Түрээсийн орлогоос шүүгч нарт **3500**, ажилтнуудад **1500** төгрөгийн урьдчилсан төлбөрт телефоны картыг сар бүр олгож байна.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтаараа өөрийн нутагт очиж амарсан **12** шүүгч, ажилтанд очих, ирэх унааны зардал **211,5** мянган төгрөгийн тусламж, “Залуучуудын зөвлөл”-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор **300,0** мянган төгрөг, хамт олны дотроос ар гэрт нь гачигдал тохиолдсон **7** шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн гишүүн, өндөр настнуудад нийт **330,8** мянган төгрөгний буцалтгүй тусламжийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар олголоо.

Шүүгч, ажилтан эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх үед Тамгын газрын хамт олны зүгээс халамж, тусламж үзүүлэх зорилготой **168** мянган төгрөг төвлөрснөөс давхардсан тоогоор **22** шүүгч, ажилтанд бүгд **130,0** мянган төгрөгийг халамжийн сангаас гарган эргэжээ. Одоо тусламжийн сан **51,6** мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шүүгч, ажилтнуудын эрүүл мэндийн байдалд анхаарч, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгийн “Уламжлалт анагаахын тасаг”-тай тохиролцож, **“Эмнэлэгийн үйлчилгээ явуулах тухай гэрээ”** байгуулан байгууллага дээр Уламжлалт анагаахын **мэргэжлийн их эмч** ажиллуулж эхэллээ.

Ийнхүү Тамгын газар 2003 онд байгууллагаа тохижуулах, шүүгч, ажилтнуудын ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажиллав.

Улсын Дээд шүүхийн барилгын **цахилгааны их засварын ажлыг** тендерт шалгарсан “Гантранс” ХХК-иар хийлгэж дуусгав.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2003 оны 88 дугаар тушаалаар байгуулагдсан **тооллогын комисс** нь **14** хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, хуралдааны танхим, коридор, бестбюльд байгаа эд зүйлсийг хариуцсан үйлчлэгчдийн карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь менежер, нягтлан бодогчийн бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **65,889,300** төгрөгийн үнэ бүхий барилга байгууламж, **123,667,097** төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, **6,652,631** төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, **1,767,300** төгрөгний үнэ бүхий ном, **75,801,320** төгрөгний үнэ бүхий **5** автомашин тоологдлоо.

Дөрөв.Шүүх судлалын төвийн ажлын талаар

Тус төв Шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйл, Шүүхийн Судалгааны төвийн дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх, түүнчлэн Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс өгсөн үүрэг даалгаврыг ханган биелүүлэхэд Шүүхийн судалгааны төвийн үйл ажиллагааг чиглүүлэн ажиллахын тулд **26** үндсэн ажил төлөвлөснөөс **23** нь бүрэн биелэгдэж, **3** нь хагас биелэлттэй хойшлогдож байгаа бөгөөд доорхи ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

АНУ-ын “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр”, түүний удирдагч доктор Хайке Грамскоу Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй хамтран “Шүүх, шүүгчийн ажлын ачаалалыг судлах аргачлал”-ыг боловсруулан “Сант марал” судалгааны төвтэй хамтран судалгаа хийж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулжээ.

Улсын Дээд шүүхийн болон Шүүхийн судалгааны төвийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Ерөнхий шүүгчийн 2001 оны 68 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үндсэн дээр мэдээллийн Нэгдсэн сангийн программыг шинэчлэн хийлгэж "Дээд шүүхийн тайлбар, шүүхийн шийдвэрийн "Нэгдсэн сан"-г бий болгож дотоод сүлжээнд оруулав. Үүнд:

- Монгол Улсын хуулиуд;
- Улсын Их хурал, Үндсэн Хуулийн Цэц, Засгийн газрын тогтоолууд;
- Монгол Улсын Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол;
- Шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий хяналтын шатны эрүү, иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол;
- Эрүү, иргэний хэргийн танхимуудаас гаргасан зөвлөмж;
- Шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор гаргасан Ерөнхий шүүгчийн захирамж, холбогдох эрх бүхий байгууллагуудын хамтарсан захирамж, тушаал;
- Нийслэл болон орон нутгийн шүүхүүдийн ажлыг шалган тусалсан дүн зэргийг “Нэгдсэн сан”-д оруулсан бөгөөд 2000 оноос өмнө Мэдээллийн санд оруулсан хуулиудад нэмэлт өөрчлөлтийг огт тэмдэглээгүй байсныг шинэчлэн гүйцэтгэж хийв.

2003 онд Монгол Улсын **201** хуулийг Нэгдсэн санд оруулахаар хүлээн авснаас, **28** хууль нь шинээр батлагдсан, **173**-д нэмэлт өөрчлөлт орсон тул, зохих тэмдэглэлийг хийн санд оруулсан

бөгөөд Ерөнхийлөгчийн **38** зарлиг, Олон Улсын Гэрээ соёрхон баталсан болон конвенцид нэгдэн орсон хууль **15**-ийг мэдээллийн санд нэмж оруулав.

Дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудын жагсаалтыг 1959 оноос 2002 он хүртэлх хугацааг хамааруулан гаргаж эрүү, иргэн, бусад хуулийн тайлбарууд гэж ангилан, тэдгээрт өөрчлөлт орсон болон хүчингүй болсон заалтуудыг системчлэх ажлыг хийлээ.

Улсын Дээд шүүхээс эрхлэн хэвлүүлсэн “Дээд шүүхийн тайлбар, тогтоолын эмхтгэл”-ийг шинэчлэн хэвлүүлэхэд зориулан түүнд орсон өөрчлөлтийг хийж, системчлэн цэгцлэв.

Мөн 2000-2003 онд Дээд шүүхээс хууль тайлбарлаж гаргасан **28** тогтоол, 1991-2000 онд хууль тайлбарлаж гаргасан бүх **71** тогтоол, орон нутгийн шүүхийн ажлыг шалган тусалсан дүнгийн тухай **12** тогтоол, Дээд шүүхийн Эрүү, Иргэний танхимын хяналтын шатны шүүх хуралдааны тодорхой хэрэг маргаан шийдвэрлэсэн \2003 он\ эрүүгийн **69**, иргэний **65** тогтоол, Ерөнхий шүүгчийн **14** захирамж, эрүү, иргэний хэргийн чиглэлээр танхимаас гаргасан **4** зөвлөмжийг "Нэгдсэн сан"-д шинээр оруулав.

Тав. Гадаад арга хэмжээ, сургалт, семинарын талаар

Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахууд болон Тамгын газрын ажилтнууд 2003 онд гадаад болон дотоодод болсон сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо.

Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх Л.Идэр, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Д.Батбаатар нар БНСУ-ын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн урилгаар тус улсад **албан ёсны айлчлал** хийв.

Түүнчлэн Эрүү, Иргэний хэргийн танхимын бүх шүүгчид **10** хүн БНСУ-ын Дээд шүүхийн дэргэдэх сургалтын төвд мэргэшил дээшлүүлэх сургалтанд ,

Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Н.Төрбат, Иргэний хэргийн танхимын шүүгч Ц.Амарсайхан нар БНХАУ-ын Ардын шүүхийн үйл ажиллагаатай танилцах айлчлалд;

Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх Л.Идэр нар Япон улсад болсон Ази, Номхон далайн орнуудын Ерөнхий шүүгчдийн 10 дугаар бага хуралд;

Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Н.Төрбат, Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун нар ОХУ-ын Буриад улсын Дээд шүүх байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээнд;

Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх Л.Идэр нар Австри улсын Вена хотноо болсон Олон улсын Шүүгчдийн холбооны 46 дугаар хурал, түүнчлэн БНЭУ-д болсон Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 4 дүгээр бага хуралд ;

Иргэний хэргийн танхимын шүүгч Ц.Амарсайхан ХБНГУ-ын Бавари муж улсад зохион байгуулагдсан мэргэшил дээшлүүлэх сургалтанд тус тус оролцжээ.

Ерөнхий шүүгч ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн даргыг дагалдан яваа төлөөлөгчдийн хамт, Буриад улсын Дээд шүүхийн дарга, АНУ, БНХАУ, Япон улс, БНБУ, БНЭУ, БНПУ-аас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдууд, АНУ-ын Массачусетс муж улсын шүүгчид, мөн улсын Техас муж улсын Уэслианы Их Сургуулийн Азийн дээд сургуулийн захирал, профессор Ж.Спурлок, ОХУ-ын Улсын Их сургуулийн Эдийн засгийн дээд сургуулийн тэнхимийн эрхлэгч А.Э.Жалинский, ХБНГУ-ын Мюнхены Их сургуулийн институтын захирал Б.Шюнеманн, Солонгос улсын хуулийн байгууллагын төлөөлөгчид, ХБНГУ-ын “Ханнс Зайдел”-ийн сангийн Хятад Монголын асуудал хариуцсан хэлтийн дарга Ю.Вильке болон Монгол дахь суурин төлөөлөгч, ГТТХАН-ийн төслийн удирдагч, АНУ-ын “Шүүх эрх мэдлийн, шинэтгэл” хөтөлбөрийн захирал Хайке Грамскоу, төслийн удирдагч Роберт Ла Монт, Азийн сангийн суурин төлөөлөгч, “Англо-голд” үндэстэн дамжсан корпорацийн захирал зэрэг гадаадын болон олон улсын байгууллагын төлөөлөгчдийг нийт **26** удаа хүлээн авч уулзсан байна.

Түүнчлэн Хууль зүй, Дотоод хэргийн яам, Хууль зүйн Үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Хуульчдыг бэлтгэх, сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгох нь”, “Монгол Улс Олон Улсын гэрээг хэрэгжүүлэх практик асуудал” сэдэвт сургалт семинар, Санхүү, Эдийн засгийн яамнаас зохион байгуулсан “Засгийн газрын Худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийн 3 дахь шатны сургалт, Шүүхийн судалгааны төв, Хууль зүйн Үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Иргэний хууль, шинэлэг ойлголт” сэдэвт сургалт, Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан “Хүний эрх ба Олон Улсын гэрээ” сэдэвт сургалт, Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан “Захиргааны хэргийн шүүх” Олон Улсын симпозиум, Нийслэлийн шүүхээс зохион байгуулсан “Компьютерийн сүлжээний администратор” сэдэвт сургалт, Цагдаагийн Ерөнхий газраас зохион байгуулсан “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил-хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөн, Үндэсний архивын газраас зохион байгуулсан “2004 оны 1 дүгээр улиралд болох албан хэрэг хөтлөлт, архивын улсын үзлэгт хэрхэн бэлтгэх талаар чиглэл өгөх” семинарт санал бодлоо илэрхийлэх, хэлэлцүүлэгт асуулт тавих, үг хэлэх, илтгэл тавих зэргээр шүүгч, ажилтнууд идэвхтэй оролцлоо.

Шүүгч, ажилтнуудаа!

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан шүүгч О.Зандраа, А.Доржготов, М.Дамирансүрэн, Б.Доржготов, Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч Н.Чойням, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Г.Даваадорж, М.Алдар, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Ц.Оч, Г.Буяннэмэх, Эрүү, Иргэний хэргийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, Х.Батбаатар, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр, жолооч Б.Жумдаандорж, Г.Батчулуун, сантехникийн слесарь бөгөөд цахилгаанчин Б.Ширэндэв, үйлчлэгч Д.Загдсүрэн, Ц.Цэцэгсүрэн, Л.Даваажав нарт хамт олныхоо нэрийн өмнөөс талархал илэрхийлж, цаашдын ажил хөдөлмөрт нь өндөр амжилт хүсэн ерөөе!

Эрхэм шүүгчид, албан хаагчид аа!

Улирч буй 2003 онд бид багагүй зүйл хийж амжуулсан ч, шинэ 2004 онд хийх зүйл асар их байна.

Улсын Дээд шүүх, Шүүхийн байгууллагын өмнө 2004 онд дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

Нэгдүгээрт: Нийтлэг зорилтууд

1. Монгол Улсын Их хурлын 2000 оны 39 дүгээр тогтоолоор баталсан **“Монгол Улсын шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөө”**-г хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх, үүнд нийт шүүх, шүүгч, ажилтнуудын хүч анхаарлыг төвлөрүүлэх. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдлыг дүгнэх үед хийгдэж эхлээгүй байсан **36**, хэрэгжих шатанд байгаа **82** асуудлыг ажил хэрэг болгоход мэдэгдэхүйц ахиц гарган ажиллах;

2. Улирч буй 2003 оны 3 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор болсон **“Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдах ажилтны Нэгдсэн зөвлөгөөн”**-ий шийдвэр, тус зөвлөгөөн дээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үгэнд дэвшүүлсэн зорилт, зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Хууль зүй, Дотоод хэргийн сайдын гаргасан хамтарсан захирамж, тушаалыг биелүүлэхэд шүүгч, ажилтнуудын анхаарлыг төвлөрүүлэх;

3. “Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх” болон “Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль”, “Захиргааны хэргийн шүүхэд ажиллах шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын дагуу **захиргааны хэргийн шүүхийг** хууль, тогтоолд заасан хугацаанд нь мэдлэг **мэргэжлийн өндөр түвшин, ёс зүйн** зохих шаардлага хангасан **шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр** байгуулж **ажилд нь** оруулан, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны **практикийг зөв тогтоон** эхлүүлэх;

4.Шүүх, шүүгчийн талаар иргэд, олон түмэн, төр засгийн байгууллага, албан тушаалтнаас гарч буй шүүмжлэлд анхааралтай хандаж зохих хяналт шалгалтыг хийж, үндэслэлтэй үнэн зөв шүүмжлэлийн мөрөөр шуурхай арга хэмжээ авч, үндэслэл муутай бол түүнийг няцаасан, шүүхийн шийдвэрийн үнэн зөвийг тайлбарласан хариуг ил тод өгч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэд, олон түмэн шүүхийн холбоог ойр дотно болгох зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Хоёрдугаарт. Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхим / Н.Төрбат, Р.Жамъянчойжил /-д дараах зорилтыг шийдвэрлэхийг үүрэг болгох нь зүйтэй байна.

1.Шүүн таслах ажиллагаатай холбоотой шинэ багц хуулиудын талаарх тайлбарыг боловсруулан гаргах ажлыг үргэлжлүүлж, түүнд эрдэмтэд, судлаачдын санал, дүгнэлтийг сайтар тусгаж, хуулийн тайлбарын онол-практикийн түвшин, ач холбогдлыг дээшлүүлэх, тайлбарыг эмхтгэл сэтгүүлээр дамжуулан иргэд, байгууллага, албан тушаалтан, олон түмэнд хүргэх ажлыг шуурхай зохион байгуулах;

2. “Эрүүгийн байцаан шийтгэх”, “ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай “ хуулиуд шинэчлэгдэн, “Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль” анх удаа батлагдсантай холбогдуулан “Эрүү, Иргэн, Захиргааны хэргийг шүүн таслах ажиллагаанд баримтлах **Нэгдсэн бодлого**” –ыг Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3-д нийцүүлэн боловсруулж, Дээд шүүхийн Нийт шүүгчдийн хуралдаанаар батлуулж, мөрдүүлэх;

3.Дээд шүүхийн Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн **5 шүүгчийн** бүрэлдэхүүнтэй **хяналтын** шатны хуралдаан болон **Нийт шүүгчдийн** хуралдааны **дэгийг** шинээр боловсруулан батлуулж, мөрдүүлэх;

4. Анхан болон давж заалдах шатны статистик мэдээ, тайлан, “Анхан шатны болон давж заалдах шатны шүүх, шүүгчдийн ажлыг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт” Төв орон нутгийн шүүх, шүүгчдийн ажлын ачааллын нормативд судалгаа хийсний үндсэн дээр **шүүн таслах ажиллагааны болон хэргийн менежментийг** боловсронгуй болгох, шүүх, шүүгчдийн **ажлын ачааллыг тэнцвэржүүлэх**, шүүхийн **байршил**, шүүгчдийн **орон тоог зохистой хуваарилах**, сэлгэн ажиллуулах талаар тодорхой санал боловсруулж Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;

5.Хяналтын журмаар эрүү, иргэн, захиргааны хэрэг хэлэлцэх явцад Шүүгч , шүүгчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн нь илэрсэн, эсхүл шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн талаар эргэлзээ төрвөл Шүүхийн Сахилгын хороонд болон Мэргэшлийн хороонд тухай бүр нь хүсэлт тавьж, тухайн шүүгчтэй хариуцлага тооцож ажиллах.

Гуравдугаарт. Тамгын газрын дарга / Д.Эрдэнэчулуун/-д үүрэг болгох нь:

1.Дээд шүүхийн 2003 оны ажлыг дүгнэсэн **Нэгдсэн зөвлөгөөн**, танхимууд, Тамгын газар, Судалгааны төвийн зөвлөгөөн дээр шүүгч ажилтнуудаас Тамгын газарт тавьсан шүүмжлэл, хүсэлт нэг бүрийг судлан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хариуг мэдэгдэх;

2. Дээд шүүхийн барилгын дотоод засварын ажлыг батлагдсан төсөвт багтаан чанартай хийж гүйцэтгэн шүүгч, ажилтнуудын ажиллах нөхцлийг сайжруулсан байх;

3.Тамгын газрын ажилтнуудын ажлын цаг ашиглалт, хариуцлага сахилга, ажлын байрны тодорхойлолт, түүний биелэлт, ажлын ачааллын тэнцвэрт байдал, үндсэн чиг үүрэг, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдалд тавих Дотоодын хяналт шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн дутагдлыг тухай бүр нь арилгаж, шинэ залуу ажилтнуудад ажил хэргийн зөвлөгөө, туслалцаа үзүүлж ажиллах.

Дөрөвдүгээрт. Шүүхийн Судалгааны төв / П.Цэцгээ /-д үүрэг болгох нь

1.Шинээр байгуулагдах Захиргааны хэргийн шүүхийн талаар гаргах статистик мэдээ, бүртгэл, судалгааны маягтын төслийг боловсруулан, Үндэсний статистикийн газартай зөвшилцөн, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, мөрдүүлэх;

2."Анхан шатны болон давж заалдах, хяналтын шатны шүүх, шүүгчдийн ажлыг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу 2003 оны шүүн таслах ажлыг шүүх, шүүгчдээр дүгнэн байр эзлүүлж, Улсын Дээд шүүхэд танилцуулах;

3.Нийслэл, орон нутгийн шүүх, шүүгчдийн ажлын ачааллын нормативыг АНУ-ын "Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр" төслийн арга зүйн зөвлөмжид тулгуурлан боловсруулж, Шүүхийн Ерөнхий зөвлөлөөр батлуулж мөрдүүлэх, 2004 онд шүүх, шүүгчдийн ачааллыг тэнцвэртэй байлгах асуудлаар тодорхой саналыг бэлтгэн Шүүхийн Ерөнхий зөвлөлд танилцуулах;

4. Эрүү, иргэн, захиргааны шүүн таслах ажлын практикийг анхаарал татсан тулгамдсан асуудал бүрээр, танхимуудтай хамтран судлаж, **шүүн таслах ажиллагааны болон хэргийн менежментийг** боловсронгуй болгох талаар тодорхой санал боловсруулах шаардлагатай байна.

Энэ бүх зорилтыг шинэ 2004 онд та бид хамтын хүчээр шийдвэрлэж чадна гэдэгт итгэлтэй байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН 2003 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Шүүхийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай, Төрийн албаны тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон тэдгээртэй уялдуулан гарсан дүрэм, журам, Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс дотоод ажил, зохион байгуулалтын удирдлагаар хангах талаар өгсөн үүрэг, даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг тухай бүр нь хийж гүйцэтгэх явдал нь Дээд шүүхийн Тамгын газрын 2003 оны ажлын үндсэн зорилт байлаа.

Нэг.Удирдлага, зохион байгуулалт, дотоод ажлын талаар

Дээд шүүхийн нэгдсэн төлөвлөгөөнд хийж гүйцэтгэхээр **28** ажлыг төлөвлөснөөс, **25** ажил нь бүрэн биелэгдэж, “Улсын Дээд шүүх”-ийн товч танилцуулга товхимолын эхийг бэлтгэж, хэвлүүлэх ажил төслөөр хийгдсэн ч, 2004 оны 6 дугаар сард Захиргааны хэргийн танхим байгуулагдах болсонтой, “Улсын Дээд шүүхийн гол хаалгаар ордог 1-4 давхрын шатны хайсыг шинэчлэн солих” ажил хөрөнгө мөнгөний бололцоогүйгээс хойшлогдож, “Эрүү, Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдааны танхимын тавилгыг шинэчлэх, техник, тоног төхөөрөмжийг шинээр авч тавих ажлыг Ханнс-Зайделийн санд тавьж шийдвэрлүүлэх” ажил тус төслийн дүрэмд техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг, туслалцаа үзүүлэхийг зөвшөөрөхгүй болсон зэрэг шалтгаанаар биелэгдээгүй байна.

Тамгын газрын даргын зөвлөл **6** удаа хуралдаж, уг зөвлөлийн хурлаар Улсын Дээд шүүхийн 2002 оны жилийн эцсийн тооллогын дүн, тамгын газрын зарим ажилтнуудаас цалинтай, цалингүй чөлөө олгох, эрүүл мэндийн болон амьдралын хүнд байдал, ар гэрт нь хөрөнгө мөнгөний гачигдал тохиолдсон ажилтнууд, ахмадын зөвлөлийн гишүүдээс буцалтгүй тусламж олгох зэрэг нийт **18** асуудлыг хэлэлцэн Тамгын газрын даргын тушаалаар шийдвэрлэж, хүсэлт гаргагчид тухай бүр нь хариуг өгсөн байна

2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр мөрдөгдөж эхэлсэн “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн дагуу Төрийн захиргааны албан хаагчидтай “**Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ**”-г байгуулж, үйлчилгээний албан хаагчидтай байгуулдаг “**Хөдөлмөрийн гэрээ**”-г энэ оноос эхлэн улиралаар байгуулж ирлээ.

Засгийн газрын 2002 оны 19 дүгээр тогтоол, Санхүү, Эдийн засгийн сайдын 2002 оны 5В/4341 тоот албан бичиг, “Улсын Дээд шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Эрүү, Иргэний хэргийн шүүх хуралдааны зохион байгуулалт хариуцсан зааварлагч, Номын сан хариуцсан мэргэжилтний орон тоог бүтцийн өөрчлөлтөд хамааруулж, дээрхи албан тушаалтнуудын ажлыг Шүүгчийн туслах-шинжээч, Архив хариуцсан мэргэжилтний ажилтай нэгтгэж, Шүүгчийн туслах-шинжээч, Архив, номын сан хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг дахин шинэчлэн баталж, ажилтнуудад гардуулан өгч, түүнд тавигдсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэхэд хяналт тавин ажиллаж ирлээ.

Гадаадад хэлний болон магистрт суралцахаар өөрсдөө хүсэлт гаргасан зарим ажилтнуудыг эрхэлж байсан ажил, албан тушаалаас нь чөлөөлж, зарим ахмад ажилтныг өндөр насны тэтгэвэрт гарган, тэдгээрийн оронд ажиллуулах ажилтнуудыг “**Эрх зүйн мэдлэгийн сонжуур**”, “**Баримт бичиг боловсруулах чадвар**”, “**Хууль хэрэглэх ур чадвар**”, “**Компьютер дээр ажиллах чадвар**” гэсэн **дөрвөн** хэлбэрээр сонгон шалгаруулах шалгалт авч, Б.Зориг, Э.Амин-Эрдэнэ, Т.Өсөхбаяр, Б.Чимгээ нарыг шүүгчийн туслах-шинжээчийн албан тушаалд, Д.Мөнхзоригийг Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан шинжээчийн албан тушаалд, Ө.Уянгаг Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээчийн албан тушаалд, Бичээч Д.Оюунчимэгийг Бичиг хэрэг, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд, С.Мөнхжаргалыг Тамгын газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан тушаалд, Ж.Халиуныг Бичиг хүргэгчийн ажилд Тамгын газрын даргын тушаалаар тус тус томилон ажиллуулж байна.

Төрийн захиргааны албанд түр хугацаагаар томилогдон ажиллаж байсан зарим ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн захиргааны албаны мэргэшлийн шалгалтанд

оруулж, уг шалгалтанд тэнцсэн Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан шинжээч Д.Мөнхзориг, Бичиг хэрэг, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Оюунчимэг нарыг төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлж, дээрх албан тушаалд жинхлэн томиллоо.

Албан ажлын зайлшгүй шаардлага, Дээд шүхийн Ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн Ерөнхий шүүгчийн туслах-ахлах зааварлагч “Дэс түшмэл” ангиллын АА-9 зэрэглэлд, Шүүх хуралдааны зохион байгуулалт эрхэлсэн зааварлагч “Дэс түшмэл” ангиллын АА-10 зэрэглэлд байсныг дээрх албан тушаалыг Ерөнхий шүүгчийн туслах-шинжээч, Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч “Ахлах түшмэл” ангиллын АА-8 зэрэглэлд тус тус хамааруулсан Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн тогтоол гаргууллаа.

“Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзлыг хангасан Р.Ганпүрэвт, Т.Оюунханд нарт “Дөтгөөр”, Б.Баясгалан, С.Баасанцэрэн, Н.Дуламсүрэн нарт “Гутгаар”, М.Чойням, Ё.Цэрэндэжид, С.Эрдэнэчимэг нарт “Тэргүүн” зэрэг дэв олгосны зэрэгцээ, “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-д заасны дагуу жолооч Б.Пүрэв, Б.Жумдаандорж, үйлчлэгч Д.Загдсүрэн, Л.Даваажав, Ц.Цэцэгсүрэн, Б.Уртнасан нарын ур чадварын нэмэгдлийг 20-25 хувиар тус тус нэмэгдүүлэн олголоо.

Шүүгч, ажилтнуудын хурлаар эрхэлсэн ажилдаа үр бүтээл гарган ажиллаж байгаа зарим ажилтнуудыг Төрийн дээд одон, медаль болон бусад байгууллагын шагналаар шагнуулахаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу тэдний биеийн байцаалт, ажил байдлын тодорхойлолт, шүүгч ажилтнуудын хурлын тэмдэглэл зэргийг бүрдүүлэн холбогдох байгууллагуудад хүргүүлснээр Монгол Улсын **Ерөнхийлөгчийн** 2003 оны 126 дугаар **зарлигаар** Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Г.Буяннэмэх, сантехникийн слесарь бөгөөд цахилгаанчин Б.Ширэндэв нар **“Хөдөлмөрийн хүндэт медаль”**-аар шагнагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах төв, орон нутгийн байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулахад Тамгын газрын ажилтнууд идэвхтэй оролцсоны зэрэгцээ Шүүх, шүүгчдийн 2002 оны ажлын дүнг үзүүлэлтийн дагуу гарган байр эзлүүлж, тэднийг шагнаж урамшуулах тухай асуудлыг боловсруулан шийдвэрлүүлж, аймаг, нийслэл, зарим сум, сум дунд, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчдийн семинар, зөвлөгөөнийг Ханнс-Зайделийн сантай хамтран 2003 оны 3 дүгээр сарын 3-наас 6-ний өдрийн хооронд зохион байгууллаа.

Улсын Дээд шүүхээс эрхлэн гаргаж байгаад санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан хэвлэгдэхгүй байсан **“Монгол Улсын Дээд Шүүхийн Мэдээлэл”** сэтгүүлийг “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар эрхлэн гаргуулж, бүх шатны шүүхийн шүүгчид болон бусад холбогдох байгууллагуудад үнэ төлбөргүйгээр хүргүүлсэн.

Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Д.Батбаатар, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар нар **“Дээд шүүхийн Вэф сайт”**-ыг бэлэн болгож, Интернетэд байрлуулахаар мэргэжлийн хүмүүст өгснөөс гадна тэд Тоо бүртгэл хариуцсан ахлах зааварлагч С.Эрдэнэчимэгтэй хамтран **“Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны жилийн тайлан”**-г ном болгон хэвлүүллээ.

Засгийн газрын 1996 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-ын дагуу бүх шүүгчид, тамгын газрын төрийн захиргааны албан хаагчдаас “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2002 оны байдлаар гаргуулан авч, шүүгчдийн “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, ажилтнуудын “Хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референтэд өгч хадгалуулж байна.

Мөн “Төрийн албан хаагчийн бүрэлдхүүн, хөдөлгөөний 2002 оны тайлан”, “Төрийн албан хаагчийн дэлгэрэнгүй мэдээ”, “Бүтцийн өөрчлөлтөөр төрийн албанаас чөлөөлөгдсөн шүүгч, ажилтнуудын мэдээ”, “Улсын Дээд шүүхийн 2002 оны орон тоо, цалингийн сангийн мэдээ” зэргийг батлагдсан маягтын дагуу гарган Санхүү, Эдийн засгийн Яам болон Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүллээ.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” шинээр, “Шүүхийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль шинэчлэгдэн батлагдаж мөрдөгдсөнтэй холбогдуулан байгууллагын “**Хөдөлмөрийн дотоод журам**”-ыг дээрх хуулийн зүйл, заалтуудад нийцүүлэн шинэчлэн, Ерөнхий шүүгчийн 2003 оны 815 дугаар захирамжаар батлуулсан.

Төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарагдах шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2003-2004 оны хичээлийн жилд суралцаж байгаа 8 оюутны нэрсийн жагсаалтыг Тамгын газрын даргын 2003 оны 58 дугаар тушаалын хавсралтаар батлуулан, тэдний “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай гэрээ”-г Сургалтын төрийн сантай байгууллаа.

Санхүү, Эдийн засгийн сайдын 2003 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэг явуулах ажлын удирдамж”-ийн дагуу 2003 оны 2 дугаар сарын 17-ноос 3 дугаар сарын 25-ны хооронд Нийслэл болон орон нутгийн төрийн байгууллагуудад зохион байгуулагдсан “Анхан шатны нягтлан бодох бүртгэл хөтлөлт”-ийн улсын үзлэгт хамрагдан **хангалттай** дүн үзүүлээ.

Улсын Дээд шүүхийн тамгын газрын даргын 2002 оны 23 дугаар тушаалаар байгуулсан тооллогын комиссын шийдвэр, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдсаар ирсэн эвдэрч ашиглагдахгүй болсон, илүүдэлтэй байгаа компьютер, принтер зэрэг **40** нэрийн **10,425,336** төгрөгийн эд хогшил, тоног төхөөрөмжийг акталж, данснаас хасах шаардлагатай байсан тул эд хөрөнгийн жагсаалт гарган, Төрийн өмчийн хорооны тогтоол гаргууллаа.

Архангай, Төв аймаг, Сэлэнгэ аймгийн Хөтөл сум, Сүхбаатар дүүргийн шүүхэд илүүдэлтэй байгаа 95 ширхэг сандал, Нийслэлийн шүүхэд 2 ширхэг номын тавиурыг албан хэрэгцээнд нь зориулж данснаас дансанд шилжүүлсэн байна.

Манай оронд “**Амьсгалын цочмог халтай хам шинж өвчин**” гарч, Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын мөн өдрийн 135 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор дээрх өвчнөөс урьдчилан сэргийлэх талаархи яриаг Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын орлогч дарга Ж.Бямбаагаар нийт шүүгч, ажилтнуудад, “**Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэхэд байгууллага, албан тушаалтны үүрэг, гал унтраагуул ажиллуулах арга зүй**” сэдэвт яриаг Нийслэлийн Гал Түймэртэй Тэмцэх Газрын Чингэлтэй дүүрэг хариуцсан Улсын байцаагч, дэд хурандаа Л.Цэрэндоржоор тамгын газрын ажилтнуудад тус тус хийлгэлээ.

Шүүгч, ажилтнуудын болон Улсын Дээд шүүхийн Ахмадын зөвлөлийн гишүүн, өндөр настнуудын судалгааг компьютерт шинээр хийж, тэдний хувийн хэргийн баяжилтыг тухай бүр нь бүрдүүлж байгаагаас гадна тэдэнд “Ахмадын зөвлөлийн гишүүн” гэсэн үнэмлэхийг шинээр олгосон ба шүүгч, шүүхийн байгууллагын утасны жагсаалтыг шинэчлэн, шүүгч, ажилтнуудын албан хэрэгцээнд зориулан тараан өгчээ.

Клинкийн Нэгдсэн 2 дугаар эмнэлэг болон Төрийн Тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлэгээр 2003 онд үйлчлүүлэх шүүгч, ажилтнууд, тэдний эхнэр, нөхөр, ам бүлд байгаа хүүхдүүдийн судалгааг хавсралтаар гарган **дээрхи эмнэлгүүдийн захиргаанд;**

Улсын Дээд шүүхэд төрийн холбооны телефон утас тавиулах захиалгыг хэрэглэгчдийн овог нэр, албан тушаал, өрөөний дугаарын хамт хавсралтаар гарган **Төрийн Холбооны газарт;**

“Монгол Улсын Утасны лавлах ном” шинэчлэгдэн хэвлэгдэх болсонтой холбогдуулан Улсын Дээд шүүхийн утасны жагсаалтыг хавсралтаар гарган **Монголын Цахилгаан Холбоо Хувьцаат Компанид** тус тус хүргүүлээ.

Амралтын өдрүүдэд сууж ажиллах хүмүүсийн нэрсийг “Баасан” гаригт урьдчилан авч, тухайн өдрийн Харуулд өгч хэвшээд байна.

Ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг өөрсдийнх нь санал, Ерөнхий шүүгчтэй зөвшилцсөнийг үндэслэн Тамгын газрын даргын тушаалаар батлуулж, ажилтнуудыг батлагдсан

хуваарийн дагуу амруулснаас гадна тэдний өдөр тутмын цаг ашиглалтын байдлыг цаг бүртгэгчээр гаргуулан өдөр бүр удирдлагад танилцуулж хэвшлээ.

Ерөнхий шүүгчээс албан бичгээр өгсөн удаа дараагийн үүрэг, Дээд шүүхийн 2002 оны ажлыг дүгнэн ,нийт шүүгч ажилтнуудын зөвөлгөөн дээр өгсөн үүрэг даалгаварын дагуу Тамгын газрын дотоод ажлыг сайжруулах зорилгоор Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн дарга Б.Зориг, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах- туслах-нарийн бичгийн дарга Ц.Оч, Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалт хариуцсан зааварлагчийн ажлыг эрхэлж байгаа шүүгчийн туслах Д.Батбаатар, Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч Ё.Цэрэндэжид, Тоо бүртгэлийн ажил хариуцсан ахлах зааварлагч С.Эрдэнэчимэг, Бичиг хэрэг, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Оюунханд, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр нар хариуцсан үүрэгт ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаа талаар шалгаж, **заавар зөвлөгөө** өглөө.

Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхийн ажлыг иж бүрэн болон хэсэгчлэн шалган тусалсан тухай шалгалтын материалыг эмхэтгэн цэгцэлж архивын нэгж болголоо.

Бичиг хэрэг, өргөдөл, гомдлын ажил хариуцсан мэргэжилтэн эрүүгийн **276**, иргэний **243**, тамгын газрын **6**, бусад **118**, нийт **643** өргөдөл гомдол, **1190** албан бичиг, **2274** хавтаст хэрэг хүлээн авч, компьютерт бүртгэн, бүртгэл хяналтын карт нээн, удирдлагад танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хуваарилан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **3417** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад явуулсан байна.

Ерөнхий шүүгч **16** удаагийн уулзалтаар **72** иргэнийг хүлээн авч уулзах үед оролцон тэмдэглэл хөтөлж, өгсөн үүрэг, даалгаврыг холбогдох шүүгч, ажилтнуудад танилцуулжээ.

Байгууллагын албан бичгийн “Хэвлэмэл хуудас”-ыг дугаарлан Шүүгчийн туслах-шинжээч, бичээч нарт бүртгэлээр хүлээлгэн өгч, ямар нэгэн шалтгаанаар ашиглагдахгүй болж, устгах “Хэвлэмэл хуудас”-ыг буцаан авч, дугаарыг нь өөрийн бүртгэлд бүртгэн тооцож байна.

Ерөнхий шүүгчийн ажлын албаны дарга давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанаар хянагдсан эрүүгийн 39, иргэний 11 хэргийг Ерөнхий шүүгч, шүүгчдийн даалгавраар уншин судалж, даалгавар өгсөн шүүгчид саналаа танилцуулсны дээр эрүүгийн 2 хэрэгт Ерөнхий шүүгчийн дүгнэлт боловсруулжээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлын улсын комиссын санал болгосноор сум, сум дунд, дүүргийн шүүхийн шийдвэрлэсэн 73 хэргийг татан авч, шүүхийн практик нэгтгэн судалж, тэдгээр хэргүүдээс нөхөх олговор давхардуулан гаргуулсан 20, хууль зөрчсөн 2 хэргийг дахин хянуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргаж, Улсын Ерөнхий прокурорын газарт шилжүүлэн, алдаа зөрчлийг арилгуулсны дээр шүүхийн практик судалсан асуудлаараа зөвлөмж, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурорын хамтарсан “Журам тогтоож, хэрэгжүүлэх тухай” захирамж, тушаал гаргуулан нийт шүүхүүдэд хүргүүлсэн байна.

Түүнчлэн шүүхийн байгууллага 1954 оноос хойш улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, 1998 оноос хойш улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэд нөхөх олговор олгох, садан төрлийн холбоо тогтоох ажлыг хэрхэн зохион байгуулж байсан, энэхүү 3 төрлийн хичнээн хэргийг хэрхэн шийдвэрлэсэн, ямар алдаа, зөрчил гарч байсан, түүнийг хэрхэн засч арилгасан талаар судалгаа гарган, түүхчилсэн дүгнэлттэй танилцуулга боловсруулжээ.

Тухайлбал: Монголын шүүх 1954 оноос хойш улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн 25353 хүнийг цагаатгаж, 15648 хэлмэгдэгчийн нөхөх олговор 14,4 тэрбум төгрөг гаргаж олгосны дээр садан төрлийн холбоо тогтоосон 6000 гаруй, бүгд 49000 эрүү, иргэний хэрэг шийдвэрлэсэн гэсэн тоо баримт гаргасан байна.

Ерөнхий шүүгчийн туслах-шинжээч Ерөнхий шүүгчийн **828** захирамж, **10** дүгнэлт, Танхимын тэргүүний болон шүүгчийн **248** захирамж, тамгын газрын даргын **100** тушаал, **3500** албан бичигт бүртгэл хөтлөн, дугаар өгч, ёсчлон, Ерөнхий шүүгчийн өдөр тутмын ажилд биечлэн тусалж ажиллажээ.

Ерөнхий шүүгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөөлөгчдийг нийт **16** удаа тогтоосон хуваарийн дагуу хүлээн авч уулзах уулзалтыг Бичиг хэрэг, өргөдөл, гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулсан байна.

Нийт шүүгчдийн шүүх хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан шинжээч Нийт шүүгчдийн **11** удаагийн шүүх хуралдаанд оролцон, тэмдэглэл хөтөлж, хуралдаанаас гарсан **33** тогтоол, **3** тэмдэглэлийг компьютерт бичин, нийлж, ёсчлуулан бүртгэлд авч, тогтоол, хуралдааны тэмдэглэлийн хувийг холбогдох шүүх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нь хүргүүлжээ. Мөн эрүү, иргэн, цагаатгалын **20** хэргийг үдэж цэгцлэн Эрүү, иргэний хэргийн танхимын нарийн бичгийн дарга нарт хүлээлгэн өгсөн байна.

Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн дарга хяналтын шатны журмаар **774** эрүүгийн хэрэг хүлээн авч, данс бүртгэлд бүртгэн, шүүгч нарын ажлын ачааллыг гарган Танхимын тэргүүнд танилцуулсаний дагуу шүүгчдэд хуваарилуулан өгч, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн болон уншиж хянаад хариу өгсөн **828** эрүүгийн хэрэгт хэргийг эмхэтгэн үдэх, данс хаах, уутанд хийж оёх зэрэг ажиллагааг хийж, шуудангаар явуулахад бэлэн болгон Бичиг хэрэг, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн байна.

Аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүх болон прокурорын газраас ирүүлсэн хэргийг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалал тогтоолгох, шүүгч томилуулах зэрэг Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүний нийт **110** захирамжийг компьютерт бичин ёсчлуулж, холбогдох газруудад нь хүргүүлжээ.

Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-нарийн бичгийн дарга иргэний **1090** хэргийг хүлээн авч, бүрдүүлбэрийг шалгасны үндсэн дээр хэргийг хүлээн авах, эсхүл буцаах эсэх асуудлыг шийдвэрлэн, компьютерт бүртгэн, шүүгчдэд тойргийн журмаар хуваарилуулан өгснөөс гадна **1145** хэргийг эмхэтгэн үдэх, данс хаах, уутанд хийж оёх зэрэг ажиллагааг хийж, шуудангаар явуулахад бэлэн болгон Бичиг хэрэг, өргөдөл гомдлын асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн байна.

Иргэний хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдааны болон танхимын зөвлөлгөөний бэлтгэлийг ханган, танхимын дотоод ажил, жилийн ажлын төлөвлөгөө, хуулийн тайлбар, танхимын шүүгчийн туслахуудын ажлын мэдээлэл, Улсын тэмдэгтийн хураамжийн талаар хэлэлцсэн **5** удаагийн танхимын зөвлөгөөн, иргэний хэргийн танхимын хяналтын шатны **19** өдрийн **220** шүүх хуралдаанд оролцон тэмдэглэл хөтөлсөн байна.

Түүнчлэн Ерөнхий шүүгчийн шүүх бүрэлдхүүн томилсон тухай **60** захирамж, Танхимын тэргүүний гомдлыг хүлээн авахаас татгалзах тухай, гомдлыг гаргаагүйд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамж буцаах тухай нийт **75** захирамж, хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол **42**, өргөдөл гаргагчид хариу өгсөн, хэрэг буцаан хүргүүлсэн болон бусад албан бичиг **381**-ийг боловсруулан, нийлж, ёсчлуулжээ.

Эрүүгийн болон Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслахууд хяналтын шатны шүүх хуралдааны бэлтгэлийг ханган, хуралдааны оролцогчдод хурлын зарыг биечлэн мэдэгдэж, хяналтын шатны **1273** шүүх хуралдаанд оролцон тэмдэглэл хөтөлж, хуралдаанаас гарсан тогтоолыг нийлж, ёсчлуулан уг хэргийг холбогдох шүүхүүдэд, хяналтын шатны шүүх хуралдаанаас таслан шийдвэрлэх тогтоол, магадлалд өөрчлөлт орсон тухай **84** мэдэгдэх хуудас боловсруулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Дүн шинжилгээ мэдээллийн төвд тус тус хүргүүлснээс гадна шүүгчээс шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд нь туслах, бэлтгэл ажлыг хангах зорилгоор хэрэг, маргааны талаар судалгаа хийж шүүгчид танилцуулах, хяналтын шатны шүүх хуралдаанаас гарсан тогтоолын төслийг компьютерт бичих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Түүнчлэн садан төрлийн холбоо тогтоосон тухай **2100** гаруй иргэний хэргийг аймаг, нийслэл, сум, сум дунд, дүүргийн шүүхүүдээс татан ирүүлж, бүх хэргүүдийг хуваан авч, уншин шүүхийн практик судлах зорилгоор нотлох баримтын бүрдэл дутуу болон үндэслэлгүйгээр садан төрлийн холбоо тогтоосон байдлыг шалгасан байна.

Шүүгчийн туслахууд, шүүгч иргэдтэй уулзан санал хүсэлтийг нь сонсох үед байлцан, тэмдэглэл хөтлөн, түүнийг хэрэгт нь хавсаргаж, шүүгчийг эзгүйд санал хүсэлтийг нь хүлээн авч, тухай бүр нь шүүгчдээ танилцуулж ажилласан байна.

Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан шинжээч Төрийн холбооны телефон утасны кабель ашиглан, тэдний зөвшөөрлийн дагуу “Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөр” төслөөс өгсөн серверын тусламжтайгаар өөрийн байгууллагын компьютерийн сүлжээг гадаад буюу Засгийн газрын хэрэг эрхлэх газрын сүлжээнд холбуулснаар манай байгууллагын дотоод сүлжээний компьютерүүд интернэтийн сүлжээнд холбогдох бүрэн боломжтой болгосон байна.

Мөн зориулалтын 1 сервер компьютер, сүлжээнд холбогдох боломжтой болон сүлжээний картгүй байсан Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референт Б.Баясгалан, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Д.Батбаатар, Ц.Оч, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Б.Зориг, Санхүү, хангамж хариуцсан ахлах зааварлагч-нягтлан бодогч Б.Хишигсүрэн нарын компьютерүүдэд сүлжээний карт авч, бүх тохиргоог нь хийж нэгдсэн дотоод сүлжээнд холбосноор бүх компьютерүүд дотоод сүлжээнд холбогдох болж, дотоод сүлжээг тогтвортой ажиллуулах болсон.

Түүнчлэн 2 Сервер, Иргэний хэргийн танхимын тэргүүн Р.Жамьянчойжил, шүүгч Д.Батсайхан, Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын асуудал хариуцсан референт Б.Баясгалан, Ерөнхий шүүгчийн туслах-шинжээч Б.Цогт, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Д.Батбаатар, Н.Дуламсүрэн, Ц.Оч, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч М.Алдар, Г.Даваадорж, Т.Өсөхбаяр, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч Ё.Цэрэндэжид, Бичиг хэрэг, өргөдөл гомдлын ажил хариуцсан мэргэжилтэн Д.Оюунчимэг нарын компьютерүүдийн программ болон техникийн гэмтэлтэй байсныг оношлон тогтоож, форматлан хэвийн ажиллагаанд оруулах, байгууллагын өрөөнүүдийн сүлжээний кабелиудыг шалган, тасарсан буюу гэмтэлтэй, огт кабельгүй байсан өрөө рүү сүлжээний утсыг 401-406, 401-408, 401-305, 401-308, 406-409, 406-411 2ш, 308-203, 308-303, 305-205 гэсэн схемээр татаж, ерөнхий монтажыг гаргах, байгууллагын өрөөний дугаарыг нэгдсэн дараалалд оруулж, хаягыг шинэчлэх, хуучин ажиллаж байсан 2 сервер компьютерийг интернэтийн сервер болгон бүх тохиргоо болон хамгаалалтыг хийх, дотоод сүлжээн дэх компьютерүүдээ интернэтэд холбох, ил утастай байсан өрөөний сүлжээний кабелиудыг кабель далдлагчаар дарж цэгцтэй болгох, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, “Ханнс Зайдель”-ийн сангийн компьютерүүдийг байгууллагын дотоод сүлжээнд болон интернэтэд холбох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Ашиглагдахгүй, эвдрэлтэй байсан зарим компьютерүүдийг засварлан ажиллуулж, программ хангамжийн доголдолтой байгаа компьютерүүдийг засварлан хэвийн ажиллагаанд оруулах, программ нь гацсан буюу ажиллахгүй болсон компьютерүүдийг эзэмшигч ажилтнуудын дуудлагаар очиж хэвийн ажиллагаанд оруулах, системгүй болсон компьютерүүдийг форматлаж, тохирох үйлдлийн систем суулган дагалдах бүх программуудыг суулгах, техникийн гэмтэлтэй компьютерүүдийг оношилж сэлбэх, сүлжээ тасарсан тохиолдолд хэвийн ажиллагаанд оруулах, компьютерийн хэрэглээний болон мэргэжлийн талаас нь тусалцаа хүссэн ажилтнуудад зөвлөгөө өгөх, вирусний эсрэг програмыг сервер болон бусад компьютерүүд дээр суулган байнга шинэчлэх, принтерийн хор цэнэглэх, өрөөний хаяг өөрчлөх, шинээр орсон ажилтнуудын үнэмлэх бэлтгэж хэвлэх, зарим ажилтнуудын хийсэн ажил, шаардлагатай мэдээ мэдээллийг Сервэрт нөөцөлж хадгалах зэрэг ажлуудыг өдөр тутамд хийж гүйцэтгэсэн байна.

Цагаатгалын ажил хариуцсан шинжээч 163 хүнд холбогдох **103** хэрэг хүлээн авч, **100** хэргийн материалыг уншиж, шүүгчид танилцуулан шийдвэрлүүлснээс **39** хэргийг Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлж, **64** хүнийг цагаатгасны дотор овог нэр залруулсан **4** байна.

10 хүнд холбогдох **8** хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын учир шалгуулахаар Улсын ерөнхий прокурорын газарт шилжүүлж, **89** хүнд холбогдох **57** хэргийг анхны шатны шүүхийн тогтоолыг өөрчлөх үндэслэлгүй байгаа тухай өргөдөл гаргагчдад нь хариу өгчээ.

Одоогийн байдлаар үлдэгдэл хэрэг **3** байна.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгохтой холбоотой асуудлын талаар шүүгчдийн шийдвэрээр шүүх, прокурор, архивуудын болон цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, орон нутгийн салбар комиссуудтай харилцах, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шүүгчдэд танилцуулж, холбогдох газраас хэрэг материалыг татах, зарим өргөдөл, гомдлыг тодруулахаар өргөдөл гаргагчдад буцаах буюу харъяалалын дагуу шийдвэрлүүлэхээр шилжүүлэх ажлыг цаг хугацаанд нь гүйцэтгэж байна.

Хууль тогтоомжийн системчлэлийн ажил эрхэлсэн ахлах зааварлагч Ерөнхийлөгчийн зарлиг **38**, шинээр батлагдсан болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай **201** хууль, Улсын Их Хурлын **51** тогтоолыг хүлээн авч, бүртгэлд оруулан бүх өөрчлөлтийг хийн, хууль тогтоолын лавлагааг давхардсан тоогоор **131** шүүгч, ажилтнуудад өгч, гарын авлагаар ханган, “Мэдээллийн сан”-д Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамж **14**, 2000-2003 оны хууль тайлбарласан тогтоол **28**, орон нутгийн шүүхийн ажлыг шалган тусалсан дүнгийн тухай тогтоол **12**, шүүн таслах ажлын практик ач холбогдол бүхий эрүүгийн **69**, иргэний **65** тогтоол, Эрүү, Иргэний хэргийн танхимуудын гаргасан зөвлөмж **4**-ийг тус тус оруулсан байна.

Хэвлэл мэдээллийн төлөөлөгч “Зууны мэдээ”, “Монголын мэдээ”, “Өдрийн сонин”, “Үнэн”, “Хууль зүйн мэдээ”, “Бизнесийн мэдээ”, “Сэрүүлэг” сонинууд, Монголын радио, “Монгол телевиз”, “ТҮ-5”, “ТҮ-9”, “25 дугаар суваг” телевизүүд, “Монцамэ” агентлагтай байнгын холбоотой ажилласнаар шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл 180 гаруй, ярилцлага 38, телевизээр 70 гаруй нийтлэл нэвтрүүлсэн байна.

Түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр шүүхийн дутагдал, доголдолтой тал болон шүүн таслах үйл ажиллагаатай холбоотой зөрчлийг шүүмжлэн бичсэн нийт **103** нийтлэл нийтлэгдсэнийг бүртгэн, Ерөнхий шүүгчид тухай бүр нь танилцуулж, эдгээрээс шүүхийн үйл ажиллагаатай холбоотой гүтгэлгийг няцаах зорилгоор **42** залруулгыг ямар нэг хэлбэрээр сонинд нийтэлжээ. Мөн телевизээр Улсын Дээд шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бодит байдлыг илтэд гуйвуулсан нэвтрүүлэг явуулсан тул “Өнөөдөр”, “Монголын мэдээ”, “Өдрийн сонин” зэрэг сониноор дамжуулан хариу “Мэдэгдэл” гаргасан байна.

“Монгол Улсын Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлийн 2,3 дугаарын эхийг бэлтгэн хэвлүүлэх, шүүхүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Цагаатгалын асуудал хариуцсан мэргэжилтэн 393 өргөдөл, гомдол хүлээн авсны **161** өргөдөлд хэрэг татах тухай тоотыг Үндэсний төв архив, Тагнуулын Ерөнхий газрын архив, аймгуудын шүүх, архивын тасгуудад хүргүүлсний хариуд **140** хүнд холбогдох хавтаст хэргийг хүлээн авч, бүртгэлд оруулан, Танхимын тэргүүнд танилцуулж, цагаатгалын ажил хариуцсан мэргэжилтнүүдэд хуваарилуулан өгч, хянагдсан **140** хэргийг холбогдох шүүх, архивт хүргүүлснээс гадна **105** хэргийн хариуг зохих иргэд, байгууллагад өгсөн байна.

Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдааны **52** тогтоолоор **65** хүнд холбогдох хэргийг шинээр цагаатган, **7** хүний овог нэрийг өөрчлөн зөвтгүүлжээ.

Аймаг, сумдын цагаатгалын салбар комиссууд болон иргэдээс цагаатгалын үнэмлэх авах хүсэлт гаргасны дагуу бүртгэлд авагдсан материалуудаас хайлт хийж зохих хариуг өгч, цагаатгалын үнэмлэх **260**-ийг бичиж, иргэд, аймгуудын цагаатгалын комисст нь хүргүүлжээ.

Эрүү, иргэний хэргийн танхимын шүүгчийн туслахуудын туслалцаатайгаар Улсын Дээд шүүхийн бүртгэлд ороогүй **5890** шийдвэр, хэлмэгдэгчдийн судалгааны төвийн бүртгэлд орсон **7067** шийдвэрийг компьютерийн бүртгэлд оруулан хадгалсан байна.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисст 1996-2003 онд цагаатгагдсан иргэдийн дэлгэрэнгүй судалгааг гарган хүргүүлжээ.

Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн нь 2003 оны 4 дүгээр сард Үндэсний төв архиваас Улсын Дээд шүүхийн архивын ажлыг шалгаад, цаашид хийх 12 зүйл бүхий үүрэг өгсний дагуу архивын хадгаламжийн нэгжийн гарчгийн агуулга тодорхой бус бүрхэг байсан 164 нэгжийг тодорхой болгож, гадаадын орнуудтай хийсэн гэрээ, гадаадад явсан туршлага хэмээх улс орны нэр нь тодорхой бус 8 нэгжийн нэрийг тодруулан, даргын тушаалын эх, дугаарын бүртгэлийг тодорхойлон бичээгүй 21, дугаар бичигдээгүй Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, протокол 13,

Ерөнхий шүүгч болон шүүгчийн захирамж 15, дарга, орлогч дарга нарын эсэргүүцлийн дугаар бичигдээгүй 20, Дээд шүүхийн Бүгд хурлын тогтоолын дугаар бичигдээгүй байсан 55, магадлал 164, бүгд 350 нэгжийн дугаарыг тавьж, 133 нэгжийн 26600 ширхэг хуудсыг дугаарласнаас гадна байнга хадгалах хадгаламжийн 1986 оны 584 дүгээр нэгжид Ардын шүүхийн 60 жилийн ойн материал, 1993 оны 798 дугаар нэгжид Дээд шүүх болон аймаг, нийслэлийн шүүхүүдийн шүүгч нарын тангараг өргөсөн ажиллагааны материалыг, 1996 оны 867 дугаар нэгжид Монгол улсад шүүх байгуулагдсаны 70 жилийн ойн уралдаанд ирсэн уран бүтээлүүдийн материалуудыг тус тус шинээр нэмж нэгж болгон оруулсан байна.

Байгууллагын дэргэдэх “Баримт бичиг нягтлан шалгах аргазүйн комисс”-ыг Ерөнхий шүүгчийн захирамжаар шинэчлэн батлуулж, архивт өгөөгүй байсан 2002 оны баримтыг хариуцсан ажилтнуудаас хүлээн авч, бүртгэлд оруулжээ.

Түүнчлэн давхардсан тоогоор шүүгч, ажилтнуудад **105** удаа **515** нэгжийн архивын баримтыг түр хугацаагаар олгож, **8** байгууллагын хүсэлтээр Улсын Дээд шүүхийн тогтоол, магадлалын хуулбарын лавлагааг архиваас хийж өгч, албан бичгээр хариу өгчээ.

Ханнс-Зайдалын сан, Азийн хөгжлийн сан, ОХУ-ын Буриад Улсын Дээд шүүхээс бэлэг болгосон **34** нэрийн **5** ширхэг орос ном, **3** ширхэг танилцуулга, **22** ширхэг англи ном, **3** ширхэг хятад ном, **8** ширхэг солонгос ном, **518,1** мянган төгрөгөөр худалдан авсан **33** нэрийн **70** ширхэг монгол ном, нийт **111** номыг номын сандаа шинээр бүртгэн, **5** төрлийн сонин, **2** төрлийн монгол сэтгүүл, **2** төрлийн орос сэтгүүлийг ангилан дугаараар нь байрлуулж, шинээр номын санд бүртгэгдсэн ном, сэтгүүлийн тухай “Мэдээлэл”-ийг **6** удаа хийжээ.

Түүнчлэн **122** хүнд уншигчийн үнэмлэх олгон, уншлагын танхимд давхардсан тоогоор **353** хүнд **450** ширхэг сэтгүүл, **1059** номоор үйлчилжээ.

Улсын Дээд шүүхийн шүүгч, ажилтнуудад **35** нэрийн **85** ширхэг номыг олгож, албан хэрэгцээнд ашиглуулсан байна.

Бичээч нь Ерөнхий шүүгчийн захирамж, дүгнэлт, Танхимын тэргүүний захирамж, шүүгчийн захирамж, Тамгын газрын даргын тушаал, албан бичиг, Улсын Дээд шүүхийн тогтоол, танилцуулга, шалгалтын материал, Шүүхийн судалгааны төвөөс гаргаж буй тойм, зөвлөмж, цагаатгалын ажилтай холбоотой материал, хуулийн тайлбар, Сахилгын хорооны дарга, гишүүдийн захирамж болон холбогдох материалууд зэрэг **72450** мөр буюу **3450** хуудас бичгийг компьютерээр бичсэн байна.

Энэ үзүүлэлт нь өнгөрсөн оныхтой харьцуулахад **10** гаруй хувиар буурсан нь бичээчийн ажлын ачаалал багассаныг харуулж байна. Бүх шүүгчийн туслахууд болон бусад ажилтнууд компьютертэй болж, бичих зүйлээ өөрсдөө бичдэг болсон.

Бичиг хүргэгч нь **1321** албан бичиг, **3262** хавтаст хэргийг холбогдох иргэд, аж ахуйн нэгж байгууллага, Цагдаагийн Ерөнхий газрын шуудан болон нийслэл, дүүргийн шүүхэд хүргэн, гардуулан өгсөн байна.

Хуулийн төв байгууллагуудын дунд / Улсын Дээд шүүх, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурорын газар, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хууль зүйн Үндэсний төв / жил бүр уламжлал болон зохиогддог “Шилжин явах цомын төлөө спортын тэмцээн”-ийг энэ жил Хүний эрхийн үндэсний комиссоос зохион явуулахад манай баг тамирчид амжилттай оролцож, эрэгтэй баг “Боулинг”, “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнүүдэд тэргүүлж “Алтан медаль”, “Гар бөмбөг”-ийн тэмцээнд **2 дугаар** байр эзэлж “Мөнгөн медаль”, “Теннис”-ий тэмцээнд **2 дугаар** байр эзэлж “Мөнгөн медаль”, эмэгтэй баг “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнд **2 дугаар** байр эзэлж “Мөнгөн медаль”, “Теннис”-ий тэмцээнд **3 дугаар** байр эзэлж, “Хүрэл медаль” тус тус хүртэж, багуудын нийлбэр дүнгээр **2 дугаар** байр эзэллээ.

Удирдлагаас чөлөө авалгүй хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 2 өдөр ажил тасалсан, албан ажил, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, ажлын байранд тамгын газрын ажилтан болон гадны хүмүүсийг архи уулгасан Сантехникийн слесарь бөгөөд цахилгаанчин Б.Ширэндэв, ажлын байранд архи

уусан Бичиг хүргэгчээр ажиллаж байсан Д.Долгорсүрэн нарт Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн сахилгын шат дараалсан шийтгэл ногдууллаа.

Хоёр. Санхүү, материаллаг хангалт, нийгмийн асуудлын талаар

Тамгын газар нь 2003 онд шинээр батлагдан мөрдөгдөж байгаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтйн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг зохих зардлаар нь аль болох үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, өр гаргахгүй, өөрийн орлогыг бүрдүүлэн ажиллахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Улсын Дээд шүүхийн 2003 оны батлагдсан төсөв **157,709,0** мянган төгрөг, тоног төхөөрөмжийн зардалд зориулагдсан хөрөнгө оруулалтын төсөв **10,0** сая төгрөг байсан. Урсгал зардлын батлагдсан төсвөөс **154,051,5** мянган төгрөгийг авч, төсөвт тусган төсвийн зардлыг зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь тайлагнаж ирлээ.

Харин батлагдсан төсвөөс дутуу санхүүжилт хийгдсэн мэт харагдаж байгаа нь зарим орон тооны бүтцийн өөрчлөлтийн зөрүү цалингийн сангийн **3,657,5** мянган төгрөгийг Санхүү,Эдийн засгийн яам шууд хасч санхүүжилт хийсэн болно.

Урсгал зардлын төсвийг хэрхэн зарцуулсныг зүйл тус бүрээр нь танилцуулбал:

- Бичиг хэрэг, аж ахуйн зардалд **5,325,0** мянган төгрөг төлөвлөснөөс **6,092,3** мянган төгрөг зарцуулагдсан бөгөөд **767,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гэрэл цахилгааны зардалд **2,667,6** мянган төгрөг төлөвлөснөөс **2,808,0** мянган төгрөг зарцуулагдаж, **140,7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Түлш, халаалтын зардалд **13,242,7** мянган төгрөг төлөвлөснөөс **12,373,1** мянган төгрөг зарцуулагдаж, **869,6** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Тээвэр, шатахууны зардалд **5,754,3** мянган төгрөг төлөвлөснөөс **6,119,0** мянган төгрөг зарцуулж, **364,7** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Шуудан, холбооны зардалд **9,146,4** мянган төгрөг төлөвлөснөөс **11,173,0** мянган төгрөг зарцуулагдаж, **2,026,6** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Цэвэр, бохир усны зардалд **984,0** мянган төгрөг төлөвлөснөөс **316,4** мянган төгрөг зарцуулагдаж, **667,6** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Дотоод албан томилолтын зардалд **1,200,0** мянган төгрөг төлөвлөснөөс **2,089,5** мянган төгрөг зарцуулагдаж, **889,5** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гадаад албан томилолтын зардалд **5,320,0** мянган төгрөг төлөвлөснөөс **6,242,3** мянган төгрөг зарцуулагдаж, **922,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Ном, хэвлэл авах зардалд **720,0** мянган төгрөг төлөвлөснөөс **1,065,90** мянган төгрөг зарцуулагдаж, **345,9** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Нормын хувцас авах зардалд **127,5** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **113,6** мянган төгрөг зарцуулагдаж, **13,9** мянган төгрөг хэмнэгдсэн;
- Урсгал засварын зардалд **500,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **2,030,3** мянган төгрөг зарцуулагдаж, **1,530,3** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Гадаад зочны зардалд **5,100,0** мянган төгрөг төлөвлөснөөс **5,972,2** мянган төгрөг зарцуулагдаж **872,2** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Ерөнхий шүүгчийн байрны зардалд **303,4** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **303,4** мянган төгрөг зарцуулагдсан;
- Буцалтгүй тусламж, тэтгэлэг урамшууллын зардалд **6,361,2** мянган төгрөг төлөвлөснөөс **6,906,1** мянган төгрөг зарцуулагдаж, **544,9** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Төлбөр хураамж болон бусад зардалд **1,173,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **3,100,0** мянган төгрөг зарцуулагдаж, **1,927,0** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Бараа үйлчилгээний бусад зардалд **51,563,7** мянган төгрөг төлөвлөснөөс **59,799,3** мянган төгрөг зарцуулагдаж, **8,235,6** мянган төгрөгөөр **хэтэрсэн**;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд **20,841,1** мянган төгрөг төлөвлөснөөс **19,442,1** мянган төгрөг зарцуулагдаж, **1,399,0** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;
- Цалин хөлс, нэмэгдлийн зардалд **78,943,0** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **63,017,7** мянган төгрөг зарцуулагдаж, **15,925,3** мянган төгрөгөөр хэмнэгдсэн;

- Бүтцийн өөрчлөлтөд хамаарагдсан цалингийн зардалд **7,647,7** мянган төгрөг төлөвлөгдснөөс **4,886,3** мянган төгрөг зарцуулагдаж, **2,761,4** мянган төгрөгийг Сөнхүү, Эдийн засгийн яам шууд хассан байдалтай байна.

2003 онд шүүгч, ажилтнуудынхаа ая тухтай ажиллах нөхцлийг сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, зарим хүмүүсийг шагнаж урамшуулах, байгууллагын тохижилт, засвар, үйлчилгээ, бичиг хэргийн зардал болон бусад зардалд **23,4** сая төгрөг зарцуулсан байна.

Тухайлбал: Морин хуурны үнэнд **250,0** мянган төгрөг, Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн “Цагаан сар”-ыг тохиолдуулан Ахмад настнууддаа хүндэтгэл үзүүлж, тэдэнд бэлэг дурсгалын зүйл өгөхөд **350,0** мянган төгрөг, Эх үрсийн баярыг тохиолдуулан шүүгч, ажилтнуудынхаа Ерөнхий боловсролын дунд сургуульд суралцдаг болон цэцэрлэгийн насны хүүхдүүдэд бэлэг авч өгөхөд **350,0** мянган төгрөг, шүүгч, ажилтнуудыг шагнахад **512,2** мянган төгрөг, шүүх хуралдааны танхимд 2 ширхэг индэр авахад **228,8** мянган төгрөг, хяналтын шатны шүүх хуралдааны танхимын шалны хулдаас авахад **35,8** мянган төгрөг, албан бичиг хүргэх шуудангийн зардалд **3,544,8** мянган төгрөг, албан бланк авахад **590,9** мянган төгрөг, дугтуй авахад **542,3** мянган төгрөг, бичгийн 1, 2 дугаар цаас авахад **401,8** мянган төгрөг, өсгөгч, микрофон, чанга яригч авахад **3,029,1** мянган төгрөг, диктафон авахад **70,9** мянган төгрөг, сүлжээний кабель, компьютерийн сэлбэгэнд **150,7** мянган төгрөг, компьютерийн 1 ширхэг ширээ авахад **114,9** мянган төгрөг, компьютерийн хард диск авахад **150,1** мянган төгрөг, компьютерийн сүлжээний карт авахад **65,0** мянган төгрөг, өрөөнүүдийн компьютерийн сүлжээний кабель утас далдлагч авахад **60,1** мянган төгрөг, нөтбурын засварт **30,0** мянган төгрөг, факсын засварт **129,8** мянган төгрөг, факсын хор авахад **37,9** мянган төгрөг, канон, принтерийн засварт **351,0** мянган төгрөг, канон, принтерийн хор авахад **1,245,0** мянган төгрөг, 1 ширхэг тоос сорогч авахад **59,9** мянган төгрөг, 2 ширхэг эвхдэг сандал **32,0** мянган төгрөг, чүль, хөшиг авахад **53,0** мянган төгрөг, дулааны шугам солиход **1,645,9** мянган төгрөг, автомашины даатгал, татвар, оношлогоонд **275,0** мянган төгрөг, Ерөнхий шүүгч Ч.Ганбат, Танхимын тэргүүн Р.Жамьянчойжил, шүүгч Д.Батсайхан, С.Нямжав, шүүгчийн туслахаар ажиллаж байсан Р.Ишцог нарын 50, 60 насны ойг тохиолдуулан дурсгал болгосон дурсгалын зүйлсийн үнэнд **420,0** мянган төгрөг, Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүнүүдийн гар утасны нэгжийн төлбөрт **854,9** мянган төгрөг, шүүгч, ажилтнуудын телефон утасны зардалд **5,208,0** мянган төгрөг, Шүүхийн Ерөнхий зөвлөл байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан Улсын Их хурлын гишүүн Д.Дэмбэрэлцэрэн, Баянхонгор аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч асан Л.Цэдэндамба нарыг шагнах Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг” хийлгэхэд **85,3** мянган төгрөг, Улсын Их хурлын гишүүн Д.Дэмбэрэлцэрэн, Баянхонгор аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч асан Л.Цэдэндамба, Булган аймаг дахь Сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч З.Хосбаяр, Ховд аймаг дахь Сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Б.Бямбасүрэн, Нийслэлийн шүүхийн Тамгын хэлтсийн хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ё.Ганбат, нярав Ш.Осорхүү нарыг шагнахад **250,0** мянган төгрөг, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн шүүх байгуулагдсаны 10 жилийн ойг тохиолдуулан дурсгал болгосон дурсгалын зүйлсийн үнэ **97,0** мянган төгрөг, Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч Д.Даваасүрэн, нарийн бичгийн дарга Д.Ганзориг нарыг шагнахад **110,0** мянган төгрөг, Сүхбаатар аймгийн шүүхийн барилга барих ажилд идэвхитэй оролцсон 5 ажилтны шагналд **192,5** мянган төгрөг, Төрийн тусгай хамгаалалтын газар байгуулагдсаны 65, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг байгуулагдсаны 70 жилийн ойг тохиолдуулан дээрхи байгууллагуудаас санал болгосон ажилтнуудыг шагнахад **75,0** мянган төгрөг, гадаадын зочид төлөөлөгчдийг хүлээн авах, хүндэтгэлийн зоог барих, бэлэг дурсгалын зүйл өгөхөд **3,338,3** мянган төгрөг, шүүгч нарт гадаад дипломат паспорт авахад **152,0** мянган төгрөг, шинэ жилийн арга хэмжээнд **1,240,0** мянган төгрөг үйлчлэгч нарын хувцасанд **113,6** мянган төгрөг, цэвэрлэгээний материалд **335,9** мянган төгрөг, тус тус төсвөөс зарцуулж, санхүүгийн тайлан балансад тусгалаа.

Түүнчлэн **8,561,8** мянган төгрөгийн **түрээсийн орлого** орсноос **8,324,3** мянган төгрөгийг дараах арга хэмжээнд зарцуулаад байна.

Тухайлбал: Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн “Цагаан сар” болон “Ахмадын өдөр”-ийг тохиолдуулан Ахмад настанууддаа хүндэтгэл үзүүлж тэднийг хооллуулахад **512,3** мянган төгрөг, Олон Улсын Эмэгтэйчүүдийн баяр “Мартын 8”-ныг тохиолдуулан эмэгтэйчүүддээ өгсөн бэлэг дурсгалын зүйлд **475,9** мянган төгрөг, төрийн далбаа авахад **18,0** мянган төгрөг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнагдсан шүүгч, ажилтнуудыг хүлээн авч, баяр хүргэх ажиллагаанд **267,2** мянган төгрөг, Нийт шүүгчдийн болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцогчдод цайны үнэнд **121,5** мянган төгрөг, хуулийн байгууллагуудын “Шинэ жил”-ийн арга хэмжээнд **570,0** мянган төгрөг, Вэйф сайтад оруулах зурагны үнэ **28,0** мянган

төгрөг, гадаадын зочдын зоогт **794,9** мянган төгрөг, гадаадын зочдод зориулж ус, чихэр авахад **206,2** мянган төгрөг, шүүгч, ажилтнуудаа салхинд гаргаж, “Залаатын ам” дахь амралтанд явахад **523,7** мянган төгрөг, жил бүр хуулийн байгууллагуудын дунд уламжлал болон зохиогддог спортын тэмцээнд **372,9** мянган төгрөг, автомашины сэлбэгэнд **1,199,4** мянган төгрөг, гэр хороололд амьдардаг ажилтнуудад нүүрс авч өгөхөд **101,0** мянган төгрөг, 2 дугаар давхрын коридорын шал засварлахад **60,0** мянган төгрөг, шүүгч нарт зөөлөн, эргэдэг сандал авч өгөхөд **1,055,6** мянган төгрөг, Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг” хийлгэхэд **44,0** мянган төгрөг, шүүгч, ажилтнуудад утасны карт авч өгөхөд **386,1** мянган төгрөг, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн шүүх байгуулагдсаны 10 жилийн ойд **86,0** мянган төгрөг, Архангай аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд **120,0** мянган төгрөг, Төв аймаг байгуулагдсаны 80 жилийн ойд **159,5** мянган төгрөг, Буриадын шүүх байгуулагдсаны 80 жилийн ойд **70,0** мянган төгрөг, зарим өрөөний хагархай цонх шиллэхэд **40,0** мянган төгрөг, цэвэрлэгээний материалд **40,0** мянган төгрөг, бусад зардалд \ Морин хуур залах, интернетийн утас солих, узелийн өрөөний цонхны хаалтийг солих, плёнк угаалгах, 1 дүгээр давхрын 00-ийн өрөөний почки солих, 2 дугаар давхрын 00-ийн өрөөний угаалтуур солих гэх мэтэд\ **430,8** мянган төгрөг, шинэ жилийн арга хэмжээний зардалд **148,8** мянган төгрөг тус тус зарцуулж, үлдэгдэл **1,0** сая төгрөгийг байгууллагын шинэ жилийн арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөд байна.

Шинэчлэгдэн батлагдсан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу 2004 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шүүгч, ажилтнуудад хоолны зардлыг ажилласан хоног тутамд **1000** төгрөгөөр тооцон олгох болсон.

Түүнчлэн шүүгч, ажилтнуудын эрүүл мэндийн байдалд ихээхэн анхаарч, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгийн “Уламжлалт анагаах тасаг”-тай “Эмнэлэгийн үйлчилгээ явуулах тухай гэрээ” байгуулан байгууллага дээр Уламжлалт анагаахын мэргэжлийн их эмч ажиллуулж эхэллээ.

Төрийн албаны тухай хуульд заасны дагуу ээлжийн амралтаараа өөрийн төрсөн нутагт очиж амарсан 12 шүүгч, ажилтанд очих, ирэх унааны зардал **211,5** мянган төгрөгийн тусламж, “Залуучуудын зөвлөл”-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор **300,0** мянган төгрөг, хамт олны дотроос ар гэрт нь гачигдал тохиолдсон **7** шүүгч, ажилтан, Ахмадын зөвлөлийн гишүүн, өндөр настнуудад нийт **330,8** мянган төгрөгний буцалтгүй тусламжийг Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар олголоо.

Шүүгч, ажилтнуудаас өвчлөн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх үед Тамгын газар, хамт олны зүгээс халамж, тусламж үзүүлэх зорилготой халамжийн санд **168,0** мянган төгрөг бүрдсэнээс, давхардсан тоогоор **22** шүүгч, ажилтныг **1-2** удаа **5000-10000** төгрөгөөр, нийт **130,0** мянган төгрөгийг халамжийн сангаас гарган эргэж, одоо **51,6** мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2002 онд тамгын газраас байгууллагаа тохижуулах, шүүгч, ажилтнуудын ая тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн анхаарч ажилласан.

Тухайлбал: Улсын Дээд шүүхийн барилгын цахилгааны их засварын ажлыг зайлшгүй хийх шаардлагатай байсан тул уг ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн материалыг бэлтгэн, урилгыг нийтэд “Өдрийн сонин”-гоор зарлан мэдээлсний дагуу **4** оролцогч тендерийн материалаа ирүүлснийг “Тендерийн хорооны гишүүд, үнэлгээний ажлын хэсэг”, “Тендерийн хороо”-ны дүгнэлтийг үндэслэн “Гантранс” ХХК-ийн гүйцэтгэгчээр шалгаруулан, тендерийн зөвлөмжийг Санхүү, Эдийн засгийн яаманд хүргүүлэн, тэдгээртэй гурвалсан гэрээг байгуулж, цахилгааны их засварын ажлыг 2003 оны 5 дугаар сарын 20-ноос 6 дугаар сарын 20-ны хооронд хийлгэж дуусган, Цахилгааны улсын байцаагчийг байлцуулан уг ажлын гүйцэтгэлийг “Техникийн комисс”-ын бүрэлдэхүүнтэйгээр хүлээн авч, хэвийн үйл ажиллагаанд орууллаа.

Улсын Дээд шүүхэд хэрэглэгдэж байгаа албан бичгийн хэвлэмэл хуудасны маягуудыг хэвлүүлж, байнга бэлэн байлгаж байгаагаас гадна бичиг хэргийн хэрэгсэл, бичгийн цааснуудыг хэрэглэх хэмжээгээр нь шаардах хуудсаар шүүгч, ажилтнуудад тараан өгч, үйлчлэгчдийг нормын хувцасаар жигдрүүлэн, сар бүр цэвэрлэгээний материалаар тасралтгүй хангаж байна.

Байгууллагад ашиглагдаж байгаа **29** ширхэг телефон утсыг “Монголын Цахилгаан холбоо компани”-тай байгуулсан гэрээний дагуу урьдчилсан төлбөрт тооцоонд орууллаа.

Түрээсийн орлогоос шүүгч нарт **3500**, ажилтнуудад **1500** төгрөгийн урьдчилсан төлбөрт үйлчилгээний картыг сар бүр олгож байна.

Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор принтерийн хорыг цэнэглэгчээр дахин цэнэглэн ашиглаж байна.

Энэ оны 2 дугаар улиралд улс орон даяар зохиогдсон “Автотехникийн улсын үзлэг”-т байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа **5** автомашиныг орууллаа.

Улсын Дээд шүүхийн Тамгын газрын даргын 2003 оны 88 дугаар тушаалаар байгуулагдсан тооллогын комисс нь 14 хоногийн хугацаанд байгууллагын жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг шүүгч, ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, хуралдааны танхим, коридор, бестбюльд байгаа эд зүйлсийг хариуцсан үйлчлэгчдийн карттай нь, агуулахад хадгалагдаж байгаа эд зүйлсийг үлдэгдлээр нь менежер–нягтлан бодогчын бүртгэлтэй тулган тоолсон байна.

Байгууллагын дүнгээр **65,889,300** төгрөгийн үнэ бүхий барилга байгууламж, **123,667,097** төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө, **6,652,631** төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, аж ахуйн материал, **1,767,300** төгрөгийн үнэ бүхий ном, **75,801,320** төгрөгийн үнэ бүхий бүхий **5** автомашин тоологдлоо.

Тооллогын комиссын саналыг үндэслэн эвдэрч хэмхрэн ашиглагдахгүй болсон зарим эд хөрөнгийг акталж, данснаас хасах шаардлагатай тул Төрийн өмчийн хорооноос зохих зөвшөөрөл авч шийдвэрлүүлэхээр бэлтгээд байна.

Гурав. Сургалтын талаар

2003 онд Тамгын газрын ажилтнууд гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалт, семинаруудад идэвхтэй оролцлоо.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн урилгаар тус улсын “Шүүхийн үйл ажиллагаатай танилцах” айчлалд Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ч.Ганбатыг дагалдан Гадаад харилцааны асуудал эрхэлсэн зөвлөх Л.Идэр, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Д.Батбаатар нар оролцлоо.

Хууль зүй, Дотоод хэргийн яам, Хууль зүйн Үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Хуульчдыг бэлтгэх, сонгон шалгаруулах тогтолцоог боловсронгуй болгох нь” сэдэвт семинарт Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун, Хууль зүй, Дотоод хэргийн яам, Хууль зүйн Үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Монгол Улс Олон Улсын гэрээг хэрэгжүүлэх практик асуудал” сэдэвт сургалтад Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, Санхүү, Эдийн засгийн яамнаас зохион байгуулсан “Засгийн газрын Худалдан авах ажиллагааны дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийн 3 дахь шатны сургалтанд Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Шүүхийн судалгааны төв, Хууль зүйн Үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан “Иргэний хууль, шинэлэг ойлголт” сэдэвт сургалтад Шүүхийн судалгааны төвийн захирал П.Цэцгээ, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, Хүний эрхийн Үндэсний Комиссоос зохион байгуулсан “Хүний эрх ба Олон Улсын гэрээ” сэдэвт сургалтад Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч Г.Буяннэмэх, Н.Дуламсүрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч М.Алдар, Э.Амин-Эрдэнэ Ханнс-Зайделийн сангаас зохион байгуулсан “Захиргааны хэргийн шүүх” Олон Улсын симпозиумд Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, Тоо бүртгэл хариуцсан ахлах зааварлагч С.Эрдэнэчимэг, Нийслэлийн шүүхээс зохион байгуулсан “Компьютерийн сүлжээний администратор” сэдэвт сургалтад Компьютерийн техник хангамжийн асуудал хариуцсан шинжээч Д.Мөнхзориг, Цагдаагийн Ерөнхий газраас зохион байгуулсан “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил-хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнд Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, Үндэсний архивын газраас зохион байгуулсан “2004 оны 1 дүгээр улиралд болох албан хэрэг хөтлөлт, архивын улсын үзлэгт хэрхэн бэлтгэх талаар чиглэл өгөх” семинарт Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр нар санал бодлоо илэрхийлэх, хэлэлцүүлэгт асуулт тавих, үг хэлэх, илтгэл тавих зэргээр идэвхитэй оролцлоо.

АНУ-ын Адвокат интернейшнл байгууллагын дэмжлэгтэйгээр 3 дахь жилдээ зохион явуулж буй Англи хэлний сургалтанд Компьютерийн техник хангамжийн ажил хариуцсан шинжээч Д.Мөнхзориг, Ерөнхий шүүгчийн туслах Б.Цогт, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Д.Батбаатар, Н.Дуламсүрэн, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах М.Алдар, Тамгын газрын дотоод ажил хариуцсан мэргэжилтэн С.Мөнхжаргал нар өөрсдөө санаачлага гарган 7 хоногт 3 удаа ажлын бус цагаар хичээллэж, гадаад хэл бие даан суралцахдаа идэвх чармайлт гарган суралцаж байна.

Шүүгчийн туслах-шинжээч Г.Даваадорж Монголын радиогийн “Соёмбо” нэвтрүүлэгээр “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа шүүхийн практик, түүнийг боловсронгуй болгох нь” сэдвээр ярилцлага өгснөөс гадна МУИС-ийн Хууль зүйн Дээд сургуулийн Магистрын сургалтад суралцан дүүргэж, “Хууль зүйн ухааны магистр”-ын зэрэг хамгаалсан байна.

2003 онд бусдаасаа илүү идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажилласан Хангамжийн асуудал хариуцсан менежер С.Баасанцэрэн, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч М.Чойням, Эрүүгийн хэргийн танхимын шүүгчийн туслах-шинжээч М.Алдар, Г.Даваадорж, Б.Зориг, Иргэний хэргийн танхимын шүүгчийн туслах Д.Батбаатар, Ц.Оч, Эрүүгийн шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Ц.Нарангэрэл, Иргэний шүүн таслах ажлын судалгаа хариуцсан шинжээч Х.Батбаатар, Архив, номын сан хариуцсан мэргэжилтэн Ж.Тэгшдэлгэр, жолооч Г.Батчулуун, Б.Жумдаандорж, сантехникийн слесарь бөгөөд цахилгаанчин Б.Ширэндэв, үйлчлэгч Л.Даваажав, Д.Загдсүрэн, Ц.Цэцэгсүрэн нарт хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлж, цаашдын ажилд нь амжилт хүсье.

2003 онд Улсын Дээд шүүхийн тамгын газар дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхэд нийт ажилтнуудын уйгагүй хөдөлмөр, идэвх санаачлага, бтээлч, хамтын ажиллагаа ихээхэн нөлөөлж, дэвшүүлсэн зорилтоо ерөнхийд нь биелүүлсэн гэж дүгнэж байна.

2004 онд Тамгын газрын ажилтнууд өөрийн ажлын байрны тодорхойлолтонд тусгагдсан ажлыг чанартай хийж гүйцэтгэх;

- Ерөнхий шүүгч, шүүгч нар, Тамгын газрын даргаас өгсөн үүрэг, даалгаврыг ёсчлон биелүүлэх;
- 2004 оны байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан өөрт холбогдох ажлуудыг бүрэн гүйцэт ханган ажиллах;
- “Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль”-д заасны дагуу зохион байгуулагдах сонгон шалгаруулалтанд сайтар бэлтгэн оролцож “Хуульч” гэрчилгээ авах;
- Цаашид Захиргааны хэргийн шүүх болон анхан шатны шүүхэд гарсан шүүгчийн орон тоонд өөрийгөө сайн бэлдэж, шүүгч болох зорилт тавих;
- Өөрийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхийн тулд бие даан суралцах;
- Ажлын цаг ашиглалтыг ягштал барьж, өөрийн мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадвараа дээшлүүлэхийн төлөө санаачлага гарган ажиллах;
- Хамт олноос зохион байгуулж буй ажлуудад бүрэн хамарч, идэвхитэй оролцож байх зэргээр өөрөө өөртөө зорилго, зорилт дэвшүүлэн ажиллах, дэвшүүлсэн зорилтоо биелүүлэхийн төлөө чармайн ажиллахыг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.